

Судалгааны ажлын үндэслэл:

Өнөөгийн нийгэмд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрх нь уух ус, амьсгалах агаар лугаа адил чухал зүйл билээ. Харин эдгээр эрх чөлөө хэрэгжих боломжийг ардчилал бидэнд бүрдүүлж өгсөн. Тиймээс Монголын сэтгүүлзүй ч мөн ардчилсан нийгэм тогтсон цаг үе буюу 1990-ээд оноос цоо шинэ зурвас үед орж, үйл ажиллагаа нь бүх талаараа өөрчлөгдөн шинэчлэгдсэн юм. Өөрөөр хэлбэл ээдрээтэй боловч баялаг агуулга бүхий цаг хугацааг туулж чөлөөт сэтгүүлзүй бүрэлдэн тогтсон гэж болно. Гэхдээ хэвлэл мэдээллийн эрх чөлөө гэдэг сэтгүүлчдийн үйл ажиллагааны бие даасан хараат бус байдал хангагдсан нөхцөлд жинхэнэ утгаараа төлөвшдөг байна. Тэр дундаа сэтгүүлчдийн бие даасан байдлыг редакци хэрхэн хангаж, редакцийн хараат бус байдал ямар түвшинд хэрэгжиж буйгаар тэдний эрх чөлөө нь хэмжигддэг гэж болно. Тиймээс манай телевизүүдэд хараат бус бие даасан байдал хэрхэн төлөвшиж, хэрхэн хангагдаж буйг судлах нь сэтгүүлзүй дэх судалгааны ажлын тулгамдсан асуудлын нэг болоод байна.

Манай оронд хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хараат бус бие даан хөгжиж буй эсэх нь эргэлзээтэй юм. Учир нь 2008 оны дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индексээр Монгол улс “Хагас эрх чөлөөтэй” орны тоонд багтжээ. Энэ баримт нь манайд чөлөөт хэвлэл төлөвшиж чадахгүй, тодорхой хүндрэл, бэрхшээлтэй тулгарч буйг харуулж байна.

Өнөөдөр хэвлэл мэдээллийн хэрэгсэл хараат бус бие даасан байдалтай үйл ажиллагаагаа явуулж чадахгүй байна. Тиймээс редакцийн хараат бус байдал жинхэнэ утгаараа хөгжихөд саад болж буй хүчин зүйл, түүнийг шийдвэрлэх арга зам, зарчмын асуудлыг онол болон практикийн үүднээс нэгтгэн дүгнэж, хэвлэл мэдээллийн хэрэгслийн эрх чөлөөг хангадаг редакцийн хараат бус байдлыг төлөвшүүлэх боломжийг судлан тодорхойлох шаардлага тулгарч буйгаас үүдэн уг сэдвийг сонгон судлалаа.

Судлагдсан байдал

Редакцийн хараат бус байдлын тухай Монголд сүүлийн арав гаруй жилийн турш ярьж, бичиж судласаар иржээ. Хэвлэлийн Хүрээлэнгээс гаргасан “Монгол дахь мэдээллийн эрх чөлөө” \УБ 2004\ судалгаа нь Монголд бие даасан мэдээллийн хэрэгсэл төлөвших, хөгжихөд тулгарч буй бэрхшээл, гарах арга зам, сэтгүүлчдийн үзэл бодлыг олон талаас нь тусгасан ач холбогдолтой бүтээл болжээ.

Түүнчлэн редакцийн хараат бус байдлын талаар “Глоб интернэшнл” ТББ-аас цогц төсөл боловсруулж иж бүрэн хандлагатай тандалт судалгаа хийж буй нь цаашид чухал хэрэглэгдэхүүн болох юм.

Хэвлэлийн хүрээлэнгийн Мэдээллийн төвийн менежер Д.Доржхорол редакцийн хараат бус байдлын асуудлаар сэтгүүлчдийн дунд тандалт судалгаа хийсэн бөгөөд уг судалгаагаар дараах дүгнэлтүүд гарсан байна. Нийт сэтгүүлчдийн 50 хувь нь буюу 2 сэтгүүлч тутмын нэг нь хараат бус үйл ажиллагаа явуулж чаддаггүй. Өөрийн бэлтгэсэн нийтлэл нэвтрүүлгээ 54.5 хувь нь чөлөөтэй нийтэлж нэвтрүүлж чаддаггүй. Судалгаанд оролцсон сэтгүүлчдийн 46.3 хувь нь ХМХ - ийн эрхлэгч, редакторууд сурвалжлагч, ажилтнуудынхаа өдөр тутмын үйл ажиллагаанд мэргэжлийн шаардлага, хяналт тавьж редакцийн хараат бус байдалд халддаг. Нийт сэтгүүлчдийн 39 хувь нь бэлтгэсэн материалаа тухайн байгууллагын тодорхой бодлогын үүднээс нийтлэдэггүй, зарим хэсгийг хасдаг гэсэн дүгнэлт гарчээ.

Судалгааны зорилго, зорилт

Хараат бус бие даасан хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай онол, практикийг хослуулан судлаж, телевизийн редакциудад хараат бус байдал ямар түвшинд байгааг социологийн судалгааны анкет, асуулгын аргаар судлан, хэвлэл мэдээллийн хэрэгслийг бие даалган хөгжүүлэхэд тулгарч буй бэрхшээлийг тодруулах зорилго тавьсан болно.

Энэхүү зорилгоос дараах зорилтууд дэвшигдэж байна. Үүнд:

-Чөлөөт бие даасан хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгслийн түвшинг тодруулах,

-Редакцийн хараат бус байдлын талаарх онолын үзэл баримтлал, дэлхий нийтийн чиг хандлага ба монгол улсад хараат бус байдал хэрхэн хангагдаж буй, сэтгүүлчид болон судлаачдын үзэл хандлагыг тодорхойлох,

-Редакцийн бие даасан хараат бус байдлыг манай улсад хэрхэн хангаж буй болон түүнд тулгарч байгаа бэрхшээлийг тодруулах,

-Редакцийн хараат бус байдлыг төлөвшүүлэхэд анхаарах гол хүчин зүйлсийг авч үзсэн болно.

Судалгааны арга зүй

Судалгааны ажлыг хийхдээ нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх судалгааны түгээмэл аргуудыг хэрэглэснээс гадна сэтгүүлзүйн судалгааны онцлогоос хамаарч, социологийн судалгааны зарим аргыг хэрэглэж уг ажлыг гүйцэтгэв.

Судалгааны ач холбогдол, шинэтгэл

Монголын сэтгүүлзүйн салбарын бүрэн шийдэгдээгүй асуудлын нэг болох редакцийн хараат бус байдлын талаар бодит мэдээлэл өгөх, цаашлаад төлөвших нөхцөл бололцоог бүрдүүлж, шийдвэрлэх арга замыг тодорхойлох ач холбогдолтой гэж үзэж байна. Урьд өмнө нь төдийлөн судлагдаж байгаагүй уг сэдвийг сонгож, түүнийг жишээ баримт, хууль эрхзүйн хүрээнд нотлон харуулахыг оролдсоноороо шинэлэг юм.

Судалгааны хүрээ

Судалгаандаа монголын телевизүүдийн редакциудад “Редакцийн хараат бус байдал” хэрхэн төлөвшиж байгаа талаар дүр зураг гарган, үнэлэлт дүгнэлт өгөхөөр монгол улсын хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль, эрүүгийн хууль, ерөнхийлөгчийн өргөн барьсан хууль болон бусад хуулийн төсөл томоохон байгууллагуудын судалгааны ажил, хэвлэл мэдээллийн хэрэгслийн сэтгүүлчид, сэтгүүлзүйн салбарын багш ажилчдыг хамруулсан болно.

Удиртгал

Сэтгүүлзүй нь нийгмийн байгуулалттай нягт холбоотой байдаг учраас манай улсын хувьд хэвлэлийн эрх чөлөө гэсэн ойлголт ардчилсан нийгэм тогтож эхэлсэн цаг үеэс улбаатай. Ардчилсан нийгэмд амьдарч буй хэн боловч үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэх, хүлээн авах, түгээх эрхгүйгээр амьдрах боломжгүй.

Харин хэвлэл мэдээллийн эрх чөлөө нь сэтгүүлчдийн үйл ажиллагааны хараат бус, бие даасан байдал хангагдсан нөхцөлд л бүрэн төлөвшдөг байна. Ардчилсан нийгэмд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрх нь уух ус, амьсгалах агаар мэт чухал зүйл билээ. Чухамхүү эдгээр эрхийн тусламжтайгаар иргэд төр засгаас явуулж буй бодлого, шийдвэрийг зөвхөн батлагдсаны дараа мэдээд зогсохгүй уг асуудлаар байр сууриа илэрхийлж хамгаалах, маргаан мэтгэлцээн өрнүүлэх, шүүмжлэх зэргээр бодлого боловсруулах болон нийтэд хүртээлтэй аливаа асуудлыг шийдвэрлэхэд оролцож, бусад ардчиллын эрхээ эдлэх боломж бүрддэг. Иймээс эдгээр эрхийг Үндсэн хууль болон бусад хуулиар баталгаажуулан хамгаалж, зөрчигдөх явдлаас сэргийлэх нь аливаа ардчилсан төрийн үүрэг юм. Өнөөгийн хурдацтайгаар хөгжин дэвшиж буй даяаршсан нийгэмд иргэд үзэл бодлоо илэрхийлэх болон мэдээлэл олж авах, түгээх эрхээ шууд өөрсдөө дангаар биечлэн хэрэгжүүлэх нь далайцын хувьд төдийлөн үр дүнтэй биш бөгөөд ялангуяа мэдээлэл олж авах эрхийн хүрээнд энэ нь хэт хязгаарлагдмал байдлаар хэрэгжинэ. Иймд нэг талаас иргэдийн дуу хоолойг нийгэмд хүргэх замаар тэдний үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хангахын зэрэгцээ нөгөө талаас бусад иргэдийн мэдэх эрхийг хангах зорилгоор ардчилсан нийгэм дэх хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг тодорхойлогддог гэж болно. Харин хэвлэл мэдээллийн хэрэгсэл үүргээ зохих ёсоор биелүүлэхийн тулд төр, түүний байгууллагаас ангид, аливаа цензурт автахгүй, хараат бус байх шаардлагыг хуульчлан хамгаалдаг ч амьдрал дээр бүрэн хэрэгждэггүй гэдэгтэй мэргэжилтнүүд санал нийлдэг.

Хараат бус хэвлэл гэдэг нь улс төр, эдийн засгийн хувьд бүрэн бие даасан редакцийн хувьд сэтгүүлчид нь чөлөөтэй, бие даасан мэргэжлийн үйл ажиллагаа явуулах боломжоор хангагдсан байхыг хэлнэ. Бид энэхүү судалгаандаа манай сэтгүүлзүйн салбарт хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгслийг хөгжүүлэхэд анхаарал татаж буй маш олон зүйл байгаа ч “редакцийн хараат бус байдлын тухай” асуудлыг сонгон авч ямар түвшинд хэрэгжиж буйг тодорхойлох оролдлого хийлээ.

Нэгдүгээр бүлэг: Хараат бус хэвлэл мэдээллийн тухай онолын үзэл баримтлал

“Ардчилсан нийгэмд мэдээллийг нийтлэх, нэвтрүүлэх эсэхээ редакци хэн нэгний ашгаас хараат бусаар өөрийн эрх мэдлээр зохицуулах харилцааг редакцийн хараат бус байдал гэнэ”¹ хэмээн хэвлэлийн хүрээлэнгийн судалгаанд онцлон тодорхойлжээ. Түүнчлэн 120 гаруй орныг эгнээндээ нэгтгэсэн Олон улсын сэтгүүлчдийн холбоо хараат бус байдлыг *“Хараат бус хэвлэл, мэдээллийн хэрэгсэл гэдэг нь Засгийн газар, улс төрийн болон эдийн засгийн хяналтаас хараат бус, мөн шаардлагатай үндсэн эд материалын болон дэд бүтцийн эрхшээлээс хараат бус байх явдал гэж үзнэ”*² хэмээн томъёолжээ.

*“Хараат” гэдэг үгийг “Монгол хэлний тайлбар толь”-д “эрхшээлд байх, ямар нэгэн улсын мэдэлд орших”*³ хэмээн тайлбарласан байна. Эндээс үзвэл “хараат бус” гэдэг нь эрхшээлээс ангид байхын нэр юм.

Угтаа “үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө бол чөлөөт засаглалын гол тулгуур харин түүний чөлөөт бус байдал нь хууль тогтоогчдыг хангалттай мэдээлэлгүй, хууль тайлбарлагчдыг хяналтгүй, ард түмнийг хуулийн шаардлагын тухай ойлголтгүй, эрх мэдлийн хил зааггүй, өөрийнх нь үүрэггүй болгож бодит байдлаас тасалж, өөр зүгт хөтөлдөгөөрөө нийгэмд ихээхэн хор хөнөөлтэй байдаг тул хэвлэлийн бодит эрх чөлөөнд түүний үүрэг зорилго, үнэ цэнэ их юм”⁴ хэмээн Эрик Багерстам “Ардчилсан нийгэм дахь хэвлэлийн эрх чөлөө” номондоо дурьджээ.

Түүнчлэн чөлөөт хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай Даян дэлхийн сэтгүүлчдийн ажил мэргэжлийн асар том байгууллага болох Олон улсын сэтгүүлчдийн холбооны гол баримт бичигт ***“Хэрвээ сэтгүүлчид авлига, ядуу зүдүү байдал, айдас хүйдсийн нөхцөлд байвал тэнд хэвлэлийн эрх чөлөө байхгүй”***⁵ хэмээн онцолсон байна. Харин чөлөөт, хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгсэл ямар байх талаар сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн ерөнхийлөгч ***Б.Галаарид “Хэвлэлийн эрх чөлөө гэдэг ойлголтыг хамгийн энгийнээр томъёолоход аливаа мэдээллийг ямар нэгэн хаалт хяналтгүйгээр үнэн бодитойгоор олон нийтэд хүргэх үйл ажиллагаа юм”*** гэжээ.

Мөн Монголын Радиогийн сурвалжлагч ***Э.Эрдэнэтуяа “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг авч явах ёстой хүмүүс бол сэтгүүлчид өөрсдөө. Хэвлэл дотроо ардчилалтай байж, сэтгүүлчид нь ёс зүйтэй байж л хэвлэлийн эрх чөлөө хөгжинө”*** гэж үзсэн бол ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн хүндэт доктор, Монголын сэтгүүлчдийн эвлэлийн хүндэт ерөнхийлөгч ***Ц.Дашдондов “Хэвлэлийн эрх чөлөөний төлөөх тэмцлийг хутгатай зүйрлэж болно. Уг хутгыг байнга хурцалж байхгүй бол ир нь дорхноо мохож, юу ч даахаа болино. Чөлөөт***

¹ “Редакцийн хараат бус байдлын судалгаа” Хэвлэлийн Хүрээлэн УБ 2007

² “Хүний эрхийн түгээмэл тунхаглал” АНУ-ын ЭСЯ, Глоб интернэшнл ТББ \УБ2008\ 82-р тал

³ “Монгол хэлний тайлбар толь” УБ 2006, 588-р тал

⁴ Эрик Багерстам “Ардчилсан нийгэм дахь хэвлэлийн эрх чөлөө”

⁵ “Глобын сонин бичиг” № 9, УБ 2007, 10-р тал

хэвлэл ч өөрцгүй. Энэ бол аймхай хүний хийдэг ажил биш. Зүрх зориг муутай бол тийшээ зүглэх ч хэрэггүй. Чөлөөт хэвлэл гэдэг хүнд бэрх агаад хүний чанар шалгах зам тул энэ замд ганцаархнаа бус олуулаа гар гараасаа барилцан хамтдаа явах учиртай” гэсэн байна.

Ямар ч зүйлд туйлын үнэн гэж байхгүйтэй адил чөлөөт гэдэг нь харьцангуй ойлголт юм. Туйлын эрх чөлөө хаана ч байдаггүй учраас үүний цаана үүрэг хариуцлага оногддог. Тиймээс ард түмний үнэн зөвийг мэдэх эрх чөлөөг дээдэлсэн хариуцлагатай, ёс зүйтэй мэргэжлийн сэтгүүлзүйг хөгжүүлэх нь чухал гэдгийг олон судлаач, мэргэжилтэн онцлон тэмдэглэжээ.

“Сэтгүүлзүйн тайлбар толь”-д тэмдэглэснээр “Чөлөөт хэвлэл, мэдээллийн хэрэгсэл гэдэг нь төр засгийн хараат бус, эдийн засгийн хувьд бүрэн бие даасан, улс төрийн байгууллын харъяалалгүй, ил тод байдал олон ургальч үзлийн индэр болсон хэвлэл мэдээллийн хэрэгслийг чөлөөт хэвлэл гэж нэрлэнэ...”⁶ гэсэн байна. Түүнчлэн чөлөөт хэвлэл мэдээллийн хэрэгслийн гол тодорхойлолтуудыг дурьджээ.

Үүнд:

1. Эдийн засгийн хувьд бүрэн бие даасан
2. Статусын хувьд бүрэн бие даасан
3. Төр, засгийн хараат бус
4. Намын харъяалалгүй
5. Ямар нэгэн улс төрийн бодлогоос ангид
6. Ил тод байдал, олон ургальч үзлийн индэр болсон
7. Нийгэм улс төрийн нийтлэг хэвлэлийн тодорхой хүрээнд үйлчилдэг
8. Хууль эрхийн хувьд чөлөөтэй ямар ч хаалтгүй байх
9. Төр засгийн үйл ажиллагаанд хяналт тавих замаар “сөрөг хүчний” үүргийг гүйцэтгэж чадахуйц байх нь жинхэнэ чөлөөт хэвлэл мэдээллийн хэрэгсэл мөн хэмээн онцолсон байна.

Тэгвэл “**Freedom house**” дэлхийн чөлөөт хэвлэлийн хорооны шинжээчид чөлөөт хэвлэл бий эсэх болон зэрэглэлийг тогтоохдоо доорх үзүүлэлтүүдийг шалгуур болгодог.

А. Тухайн оронд улсын бус олон нийтийн мэдээллийн хэрэгсэл бий эсэх,

Б. Төрөөс үзүүлдэг улс төр, эдийн засгийн дарамтаас чөлөөтэй улсын хэмжээний мэдээллийн хэрэгсэл бий эсэх,

В. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд төр, засгийн бодлого, түүний дээд тушаалтнуудыг шүүмжилж болох эсэх зэрэг юм.

“...Мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулж өгдөг хэвлэлийн эрх чөлөө тийм ч хангалттай биш байна гэж сэтгүүлчид үздэг. Тухайлбал:

“Өдрийн сонин”-ы сурвалжлагч А.Алтантуяа “Гадны нүдээр харахад эрх чөлөө хангалттай байгаа. Хэрвээ хэвлэлийн эрх чөлөөг 100 хувь гэж үзвэл бодит байдал

⁶ “Сэтгүүлзүйн тайлбар толь” М.Зулькафиль УБ 2005, 250-р тал

дээр 10 хувь нь л байна. Эрх чөлөөний 90 хувийг бид санхүүгийн дутагдлаас болж алдаж байна гэж хэлсэн байхад, **“25-р суваг ТВ”-ийн мэдээллийн албаны дарга А. Баатархуяг** “Манайд хэвлэлийн эрх чөлөө хагас хаалттай л байна. Хуулиар зохицуулдаггүй, мэдээлэл авах боломжгүй. Мэдээлэл авах түгээх боломж нь хаагдаж байхад энэ эрх чөлөөг ямар эрх чөлөө гэдэг юм бэ?” гэжээ.

МҮОНРТ-ын ММ агентлагийн тоймч Ц.Мөнхтөр: Тухайн мэдээллийн хэрэгслийг хаах, хэвлэлийн эрх чөлөөнд нь халдах зэргээр редакцийн хараат бус байдалд нөлөөлж буйг цензур гэж ойлгож байна...”

Хэвлэлийн Хүрээлэнгийн Сэтгүүлзүйн багш Р.Оюунцэцэг “...Сэтгүүлч ямар сэдвээр бичих тухайд эзэн оролцож байна. Үүгээр ч зогсохгүй тухайн сонинны санхүүжүүлэгч хүртэл нийтлэлийн бодлогод нөлөөлсөөр байна...” хэмээн тодорхойлон хэлжээ.

“Сэтгүүлчийн хэвлэн нийтлэх эрх чөлөө, хараат бус байдалд нөлөөлдөг гадаад болон дотоод хэд хэдэн хүчин зүйл байдаг бөгөөд үүнд сэтгүүлчийн мэдээлэл хайх, боловсруулах, түгээх бүхий л үйл ажиллагаанд хамааралтай эрх, сэтгүүлчийн эрэн сурвалжлах үйл ажиллагааны эрх зүйн хамгаалалт, төрийн байгууллага, албан тушаалтнаас мэдээлэл авах эрх, эх сурвалжаа нууцлах эрхийн хамгаалалт, редакцийн хараат бус байдал, сэтгүүлчийн нөлөөлсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо зэрэг бүлэг асуудлууд багтдаг. Сэтгүүлчийн хараат бус байдлыг “сэтгүүлчид мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулахад хэн нэгнээс хараат бус байж, олон нийтийн мэдэх эрхэд шударгаар үйлчлэх таатай нөхцөл боломж” гэж ойлгож болно. Үүнд саад болдог түгээмэл гурван хүчин зүйл бий. Тодруулбал:

a. Нийтлэл, нэвтрүүлгийн бодлогод цензур тавих

b. Тодорхой сэтгүүлчийн нэрийг ашиглах (Өөрт хамаагүй нийтлэл, нэвтрүүлэгт).

c. Сэтгүүлчдийн хүсэл зоригийн эсрэг нийтлэл бичих, нэвтрүүлэг хийх даалгавар өгөх зэрэг юм.⁷

Эдгээр үзэл баримтлалаас үзвэл сэтгүүлч хүн улстөр, эдийн засгаас хараат бус байхын зэрэгцээ эзэмшигч удирдлагаас хараат бусаар үйл ажиллагаа явуулах шаардлагатай. Зарим улс оронд үүнийг маш сайн хуульчилжээ. Гэхдээ ихэнх оронд өөрийн дотоод зохицуулалтаар хянадаг байна. “Хараат бус байдал нь сэтгүүлчийн үнэт зүйл. Хараат бус байж л үнэнийг хэлж чадна. Хараат бус байдал хэдий чинээ алдагдана, үнэт зүйл нь байхгүй болно” хэмээн Хэвлэлийн эрх чөлөөний төлөө тууштай тэмцэгч “Глоб интернэшнл” ТББ-ын тэргүүн Х.Наранжаргалын хэлсэнчлэн хэвлэл мэдээллийн хэрэгсэл хэнээс ч, юунаас ч хараат бус байж чадах эсэх талаар сэтгүүлзүй өндөр хөгжсөн ямарч оронд ярьсаар л байдаг. Хэнээс ч юунаас ч зуун хувь хараат бус сэтгүүлзүй гэж байдаггүй гэдэгтэй олон хүн санал нийлдэг хэвлэл мэдээллийн хараат байдлыг багасгахын төлөө өндөр хөгжилтэй оронд байнга хүчин чармайлт гаргаж иржээ. Судлаачдын үзэж буйгаар хэвлэл мэдээллийн хэрэгслийн хараат байдалд дараах хүчин зүйлс хамгийн их нөлөөлдөг. Тодруулбал:

⁷ М.Батсуурь “Эрх зүйн зохицуулалт ба харьцуулалт” судалгааны тайлан \2-р тал\

1. Улс төр, үзэл суртлын нөлөөллөөс хараат байдал

Хэвлэл мэдээллийн хэрэгслийг улс төр үзэл суртлын нөлөөллөөс ангид байлгахын тулд нэн тэргүүнд хэвлэл мэдээллийн эрх чөлөөг эрхзүйн орчинд баталгаажуулж өгөх хэрэгтэй.

Улс төрчдийн ёс зүй, соёл, ардчилсан нийгэм байгуулах чин хүсэл эрмэлзэл, Хэвлэл Мэдээллийн Хэрэгслийн удирдлагын соёл, ардчилсан сэтгүүлзүйн тухай ойлголт, мэдлэг боловсрол, сэтгүүлчдийн өөрсдийн боловсрол, мэргэжлийн үүргийн тухай ойлголт зэрэг нь улс төрийн нөлөөллөөс ангид сэтгүүлзүйг хөгжүүлэхэд нэлээд нөлөөтэй юм.

Түүнчлэн хэвлэлийн эрх чөлөө нь мэдээлэл түгээгчид маш их боломж олгодог. Энэ онцгой нөхцөл боломжийг хэмжээ хязгааргүй ашиглавал хэвлэлийн эрх чөлөөг бүрдүүлэгч хүчин зүйлсийн зохист харьцаа, тэнцвэр алдагдаж, гажуудал үүснэ. Үүнээс сэргийлэх, тэнцвэржүүлэх, аль нэг нам, улс төрийн үзлийг сурталчлахгүй байх нь сэтгүүлч хүний үүрэг, нөгөө талаар ёс зүй мөн.

2. Мэдээллийн эх сурвалжаас хараат байдал

Хэвлэл мэдээллийн байгууллага нь үйл ажиллагааны мөн чанарын хувьд эх сурвалжаас байнга хамаарч байдаг. Олон нийтийг бодитой, тэнцвэртэй мэдээллээр хангахын тулд сэтгүүлч заавал ямар нэгэн эх сурвалжаас мэдээлэл авна. Зөрчилтэй мэдээллийг нуун дарах эрмэлзэл, төрийн байгууллагын хүнд суртал, эрх мэдэлтэн болон арилжааны томоохон компаниуд өөрсдийнхөө тухай зөвхөн эерэг мэдээлэл цацуулах сонирхол зэрэг нь мэдээлэл авах боломжийг хүндрүүлж, эх сурвалжаас хараат байдлыг бий болгодог.

Нийгмийн амьдралын гүнд орж, өдөр бүр янз бүрийн хүнтэй учирч, олон үйл явдлын гэрч болж буй сэтгүүлч хүн эх сурвалжийнхаа найдвартай эсэхийг хянах, нөгөө талаар тухайн мэдээллийн бодитой эсэхийг нягтлах үндсэн үүрэгтэй. Харин өнөөгийн байдлаар “Хүн үг хэлэх эрхтэй, түүнийг нь сэтгүүлч дамжуулах үүрэгтэй” гэсэн явцуу ойлголт манай ган үзэгтнүүдийн дунд түгээмэл байгааг судлаачид онцолжээ.

Үүнээс ангижрахын тулд улс орнууд янз бүрийн арга хөшүүргийг хэрэглэдэг байна. Тухайлбал, төрийн байгууллагын ажилтны мэдээлэл өгөх үүрэг, сэтгүүлч мэдээллийн эх сурвалжаа нууцлах эрх зэргийг хуульчлан баталгаажуулдаг.

3. Эдийн засгийн эх үүсвэрээс хараат байдал. Үүнд:

А. Зар, сурталчилгааны орлогын эх үүсвэрээс хараат байх нөхцлийг бүрдүүлэх нь хамгийн чухал юм. Нэг талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл бодит тэнцвэртэй мэдээллээр олон нийтэд үйлчлэх үүрэг хариуцлагатай боловч нөгөө талаар орлого олж ашигтай ажиллах зах зээлийн зарчим үйлчилж байдаг. Тиймээс зах зээлд оршин тогтнохын тулд далд сурталчилгаа явуулах аргаар орлого олох, зар сурталчилгаа өгдөг томоохон түнш байгууллагын талаар шүүмжлэлт мэдээлэл

хийхээс татгалзах гэх мэт сөрөг үр дагавар байнга илэрдэг гэж болно. Үүнээс зайлсхийхийн тулд дараах зохицуулалтыг хийж болдог ажээ. Үүнд:

-Далд сурталчилгааг хориглох, ивээн тэтгэлэгт нийтлэл, нэвтрүүлгийг хязгаарлах буюу хатуу дүрэм журмын дагуу явуулах, хууль эрхзүйн зохицуулалт хийх,

-Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын нэг хэсэг болох редакцийн дүрэм, ёсзүйн зарчим бий болгож мөрдөх,

-Сэтгүүлчид болон ХМБ-ын удирдлагын боловсрол, байгууллагын соёлыг дээшлүүлэх,

-Улс төрчдөд олон ургальч мэдээллийн хэрэгслийн үүрэг ач холбогдлыг ойлгож, дэмжих соёл, хүсэл эрмэлзэл бий болгох зэрэг юм.

Харин манайд томоохон уул уурхайн компаниуд хувьдаа хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй болдог жишиг тогтжээ. МУИС-ын сэтгүүлзүйн багш М.Зулькафиль “Ямар нэгэн сонгуулийн өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо нэмэгддэг үзэгдэл манайд бий болсон” гэв. Монголын хэвлэлийн хүрээлэнгийн судлаач Н.Ганчимэг ч үүнтэй санал нийлж байлаа. Мөн “Зар сурталчилгаа байнга өгдөг томоохон компани манайд ховор. Энэ талыг овжин ашиглаж компаниуд хэвлэл мэдээллийн байгууллагуудтай “ам барих” гэрээ хийдэг гэдгийг Сөрөх Тагнуулын Газрын дарга П.Баярсайхан хэлээд Спирт бал бурам, Мобиком, Оюу толгой, MCS, АPU компаниудыг дурьдлаа. Хамгийн ноцтой нь гадаадын байгууллага, аж ахуйн нэгж, иргэд төлөөлөгчид ч хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчдээр дамжуулан төрийн бодлого шийдвэр, төсөл хөтөлбөрт нөлөөлөх гэж оролдох болжээ. Рекламны багахан зах зээлтэй Монголын хэвлэл мэдээллийн байгууллагууд, цалин бага сэтгүүлч нарт юун түрүүнд мөнгө хэрэгтэй тул ёс зүй гэгчийг мартахад хүрдэг гэдгийг мэргэжилтнүүд онцолж байна.

Б. Үйл ажиллагаатай шууд уялдах дэд бүтцээс хараат байдал

Шуудан холбооны дэд бүтэц, түгээлтийн системийн гажуудал, хэвлэлтийн зардал өндөр байх, цацах станц гэх мэт хүчин зүйлүүдийн доголдол нь эдийн засгийн хараат байдалд ороход түлхэц болж байдаг. Мөн үүнд тухайн хэвлэл мэдээллийн байгууллагын бүтэц, шийдвэр гаргах шат дараалал, байгууллагын соёл, удирдлагын арга барил ч бас нөлөөлдөг ажээ.

Түүнчлэн хаягаар хүргэх систем Монголд байхгүй учир шуудан хүргэлт дээр гол асуудал үүсдэг. Түгээлтийн боловсронгуй систем байхгүйгээс үүдээд хэрэглэгчдэд сонголт хязгаарлагдмал. Мөн хөдөөд сонин хэвлэлээ хүргэх сонирхол редакциудад төрдөггүй. Шуудан захиалга, хүргэлт хийдэг зургаан байгууллага одоогоор бүртгэлтэй байдаг ажээ. Эдгээрээс нэг нь буюу “Монгол шуудан” компани төрийн өмчит аж ахуй бөгөөд ноёрхох байр суурийг эзэлдэг. Сүүлийн жилүүдэд шуудан түгээлтийн хувийн жижиг компаниуд хөгжиж буй боловч “Монгол шуудан”-тай өрсөлдөхүйц хувийн түгээлтийн сүлжээ бий болоогүй байна.

4. Эздээс хараат байдал

Кёкшүюзан Д.Батбаяр “Эх орон” телевизтэй байхдаа найзуудтайгаа зурагт үзэж суугаад эхнэрийнх нь дуу явахад зурагтын удирдлагаа шүүрэхийн оронд телевизрүүгээ утасдан “Дууг нь чангал даа” гэсэн гэдэг. Онигоо мэт хэлэгддэг энэ яриа амьдрал дээр болсон үгүйг мэдэхгүй ч өнөөдөр монголын хэвлэл мэдээллийн хэрэгсэл эздээс хараат байдгийг нотлосон егөөдөл болов уу. Мөн эзэн бүгд л “Дуугаа чангал даа” гэж хэлдэг гэдэг дээр Б.Галаарид, М.Зулькафиль нар санал нийлж байлаа. Хэвлэл Мэдээллийн Хэрэгслийн эзэд хоорондоо улс төрийн чиг хандлагаараа ч хуваагддаг аж. Үндэсний тагнуулын академийн хийсэн судалгаагаар Монголд сайт 200, телевиз 126, радио 72, сэтгүүл 102, сонин 131 байгаа аж. Тэр дундаа Ардчилсан намын 10 сонин, есөн телевиз, есөн сайт, МАН-ын 12 сонин, долоон телевиз, дөрвөн сайт, МАХН-ын нэг сонин, нэг телевиз байдаг ажээ.

2007 онд ЮНЕСКО-гийн санхүүгийн дэмжлэгтэйгээр “Монголын хэвлэл мэдээллийн салбарын төлөв байдал” төслийг “Монголын хэвлэлийн хүрээлэн” ТББ, “Глоб интернэшнл” ТББ-тай хамтран хэрэгжүүлсэн юм. Төслийн хүрээнд Дани, Их Британий шинжээчид монголын хэвлэл мэдээллийн байдалд дүгнэлт өгсөн. Тус тайлангийн дүгнэлтэнд “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл бизнес мэдээ төлбөрт нэвтрүүлгээр дүүрчээ. Үүнийг санхүүгийн бэрхшээлтэй салбараа өөд татах боломж гэж үзэж буй нөхцөлд ХМХ, сэтгүүлчид нь улс төр, бизнесийн санхүүгийн дэмжлэгээс туйлын хараат болсныг харуулж байна. Ашиг орлоготой хэвлэл мэдээллийн бизнес байх нь ховор, харин улс төр бизнесийн ашиг сонирхлыг эн тэргүүнд тавьж, тэдэнд үйлчилдэг суртал ухуулгын дуу хоолой болжээ. **ХМХ-ийн өмчлөлийн хэлбэр, ил тод байдал хангалтгүй, жинхэнэ эзнийг мэдэх аргагүй, ар талд нь гол төлөв улс төр, бизнесийн ашиг сонирхол үйлчилж байдаг...** хэмээн тодорхойлжээ. Мөн тус тайланд өнөөгийн байдлаар хэвлэл мэдээллийн хэрэгслийн төвлөрөл бага байна. Хувийн хэд хэдэн мэдээллийн хэрэгсэл нэгдэн нийлсэн ч давамгайлах байр суурь алга. Орон нутгийн хэвлэл мэдээлэлд аймгийн дарга нар давамгайлах байр суурь гүйцэтгэдэг аж. Мэдээллийн эрх чөлөөний асуудал ихээхэн сэтгэл түгшээж байна хэмээн онцолжээ.

5. Редакцийн хараат байдал

“**Редакц бүхэн өөр өөрийн ёс зүйн кодыг бий болгох хэрэгтэй**” МСЭ-ийн ерөнхийлөгч Б.Галаарид онцлон хэлжээ. Ийм ёс зүйн кодтой редакц өнөөдөр бараг л үгүй гэхэд болно. Мөн МУБИС-ын сэтгүүлзүйн багш М.Одмандах “*Редакцийн хараат бус байдлыг баталгаажуулах нэг боломж нь сонин эзэн, эрхлэгч буюу ажил олгогч, ажилтан сэтгүүлч нарын хооронд байгуулах хөдөлмөрийн гэрээ хэмээн онцолсон байна. Өнөөгийн байдлаар хөдөлмөрийн гэрээ хийж, редакцийн өөрийн онцлогийг тодорхойлох ёс зүйн дүрэм журамтай хэвлэл мэдээллийн хэрэгсэл цөөхөн байна*”⁸ хэмээн “Сэтгүүлч” сэтгүүлд дурьджээ.

Хараат бус байдлын тухай сэтгүүлчид болон судлаачид үзэхдээ:

Глоб интернэшнл ТББ-ын тэргүүн Х.Наранжаргал

“Сэтгүүлч хүн улс төр, эдийн засгаас хараат бус байхын зэрэгцээ эзэмшигч удирдлагаас хараат бусаар үйл ажиллагаа явуулах шаардлагатай. Зарим улс оронд

⁸ М.Одмандах “Орчин цагийн сэтгүүлч ба хараат бус байдал” Сэтгүүлч сэтгүүл № 01\24\, УБ 2006

үүнийг маш сайн хуульчилсан байдаг. Гэхдээ ихэнх оронд өөрийн дотоод зохицуулалтаар хянадаг. Хараат бус байдал нь сэтгүүлчийн үнэт зүйл. Хараат бус байж л үнэнийг хэлж чадна. Хараат бус байдал хэдий чинээ алдагдана, үнэт зүйл нь байхгүй болно...”

Сэтгүүлчдийн эвлэлийн хүндэт ерөнхийлөгч Ц.Дашдондов

“Хэвлэлийн эрх чөлөөг хэзээ, хэн өгөхийг хүлээж, хишиг горьдох мэт бусдыг царайчилж гуйж гувшаад байвал хэзээ ч бүтэхгүй. Тэр эрх чөлөөг тэмцэж байж л олж авна. Тэмцэнэ гэдэг түүний эсрэг үйлдэл үйлчилж байдгаас үүдэлтэй...”

МУБИС-ын Сэтгүүлзүйн тэнхмийн эрхлэгч Ж.Батбаатар:

“Хэвлэл, мэдээллийн эрх чөлөө жинхэнэ утгаараа байгаад байна уу гэвэл учир дутагдалтай, бэрхшээлтэй зүйлүүд олон бий. Хамгийн түгээмэл байгаа нэг зүйл бол эздээс хараат байдал. Санхүүгийн хараат байдлын тухай асуудал. Жишээ нь, олон улсын хэвлэлийн эрх чөлөөний тунхаг бичгүүдэд энэ тухай тусгасан. Хэвлэл санхүүгийн хувьд бие даахгүйгээр хараат бус байх тухай ярих боломжгүй.”

МУИС-ын Сэтгүүлзүйн Тэнхмийн Эрхлэгч М.Зулькафиль:

Шулуухан хэлэхэд хэвлэл мэдээллийн хараат бус, бие даасан байдалд өнөөдрийн Монголын улс төрийн тогтолцоо хамгийн их сөрөг нөлөө үзүүлж байгаа нь тодорхой шүү дээ. Өнөөдөр улс төрчид, бизнесийн бүлэглэлүүд нүүрэн дээрээ хэвлэлийн эрх чөлөө, редакцийн хараат бус байдал гэж улиг болтлоо давтдаг мөртлөө цаашаа эргээд л нөгөө гараараа хэвлэл мэдээллийг багалзуурдаж байдаг. Аль ч хэвлэл мэдээллийн хэрэгслийн ард байгаа эздүүдийн дуу хоолойг хүссэн хүсээгүй дэлгэн тавьж байгаагаараа өнөөдөр монголын хэвлэл мэдээллийн тэнцвэрт байдал ноцтой хэмжээнд алдагдаж байна. Товчхондоо тухайн орны улс төр бохир байвал хэвлэл мэдээлэл нь тэр хэмжээгээр л бохир байдаг” хэмээжээ.

Түүнчлэн манай хэвлэл, мэдээллийн салбарт сэтгүүлч хүний ажиллах нөхцөл боломжийг хааж, хэвлэн нийтлэх эрх чөлөөг боогдуулдаг “цагдан хяналт” их байгааг мэргжилтнүүд онцолсоор байна. Тухайлбал:

Ардын Эрх сонины сэтгүүлч Л.Мөнхбаясгалан “...Сэтгүүлчийн ажиллах нөхцөл бололцоог олгохгүй. Бичиж буй материалыг тухайн сонин хэвлэлд гаргахгүй, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг боогдуулахыг цагдан хяналт гэж ойлгож байна...”

МҮОНРТ-ын “Гараг” продакшны захирал Г.Бадамсамбуу: “...Хэн нэгний үзэл бодол, эрх ашигт нийцүүлэн үнэн бодит байдлыг гуйвуулахыг цензур гэнэ...”

25-р суваг ТВ-ийн захирал З.Алтай: “...Аливаа юм болгон хязгаартай байх ёстой. Хуулийн хүрээнд хийсэн бол манайх хяналт тавьдаггүй. Хариуцлагыг өндөржүүлэх дотоод хяналт байна...”

СНЭ-ийн ерөнхийлөгч Б.Галаарид: “төрийн цагдан хяналт захиргааны, эдийн засгийн, айлган сүрдүүлэх аргаар цагдан хянах, редакцийн цагдан хяналт, сэтгүүлч өөрийгөө цагдан хянах гэх мэт хэлбэр байдаг” гэжээ.

“Глоб”-ын сонин бичигт тэмдэглэснээр “Редакцийн цагдан хяналт” гэж:

**ХМХ-ийн эрхлэгч, редакторууд, сурвалжлагч ажилтнуудынхаа бэлтгэсэн материалыг хянах,*

**Сурвалжлагч, ажилтнуудынхаа бичсэн бэлтгэсэн материалыг тодорхой зорилгоор нийтлэхгүй, нэвтрүүлэхгүй байх,*

**Болохгүй гэж үзэж буй хэсгээ хасахыг шаардах,*

**Цалин хасах, ажлаас халах зэргээр арга хэмжээ авах шийтгэл ногдуулах*

**Элдвээр загнах зүхэх зэргээр дарамтлах болон бусад⁹..... гэжээ.*

2007 онд Монголын Нээлттэй Нийгэм Форум, Глоб интернэшнл ТББ-тай хамтран цензурын эсрэг дугуй ширээний ярилцлага зохион байгуулжээ. Тухайн үедээ МҮОНРТ-ийн ММ агентлагийн тоймч байсан Ц.Мөнхтөр “Цензур ба Монголын хэвлэл мэдээлэл” илтгэлдээ “Цензур”-ыг хэрхэн ангилж болох тухай дурьдсан байна¹⁰. Үүнд:

“Шууд Цензур” гэдэг нь сонин хэвлэлийг хаах, айлган сүрдүүлэх, шорон гянданд хорих, сэтгүүлчийн амь насыг бүрэлгэх багтдаг бол шууд бус буюу далд хэлбэрийн цензур нь улс төр, төрийн захиргааны, эдийн засгийн, редакцийн гэх мэт хэв шинжтэй хэмээн хуваан үзжээ.

Манай хэвлэл мэдээллийн хэрэгсэл хэн нэгний өрөөсгөл ашиг сонирхолд үйлчилдэг, хагас эрх чөлөөтэй байгаа талаар сэтгүүлзүйн салбарын судлаач, багш сэтгүүлчид тэрчлэн олон нийт болон олон улсын байгууллагынхан дүгнэдэг.

Хараат бус, чөлөөт хэвлэл мэдээллийн талаарх олон улсын байгууллага болон манай эрдэмтэн судлаачид “цензурын далд хэлбэрт хамаарах редакцийн цагдан хяналт нь бэлтгэсэн мэдээ, мэдээллийг нийтлэх, нэвтрүүлэхгүй байх, зарим хэсгийг хасч танах, өөрчлөхийг өрөөсгөл ашиг сонирхлын үүднээс шаардах, тулгахыг хэлж болох юм. Хэрэв энэ тулгалтыг биелүүлэхгүй бол сэтгүүлчийг ажлаас халах, цалин хасах, загнах, доромжлох аргуудыг хэрэглэдэг” гэж үздэг.

Редакцийн хараат бус байдалд нөлөөлдөг **гадаад хүчин зүйл** нь улс төр, эдийн засгийн нөлөөлөл юм. Хэвлэл мэдээллийн байгууллага өөрийн нийтлэл, нэвтрүүлгийн бодлогыг улс төр, эдийн засгийн хөндлөнгийн нөлөөллөөс хараат бус, бие даасан байдлаар тодорхойлж, хэрэгжүүлэх эрх мэдэлтэй байх ёстой.

⁹ “Глобын сонин бичиг” \№ 3, УБ, 2006\

¹⁰ “Глобын сонин бичиг” \№ 8, УБ 2007, 6-р тал\

Дотоод хүчин зүйлд эзэмшигч, эрхлэн гаргагч болон харилцаа удирдлагын арга барил, бүтэц зохион байгуулалтыг хамруулж болно. Өөрөөр хэлбэл гадны нөхцөл байдал ямар байхаас үл хамаарч тухайн хэвлэл мэдээллийн байгууллага өөрийн дотоод ардчиллыг хэрхэн бий болгож буйг тодорхойлно. Хэвлэл мэдээллийн байгууллагын эзэн, хөрөнгө оруулагч нь редакцийн бодлогод хөндлөнгөөс нөлөөлөхгүй байх тухай юм. Энэ нь хэвлэл мэдээллийн байгууллагын дотоод ардчиллыг илэрхийлнэ.

Нийтлэл, нэвтрүүлгийн бодлого, үйл ажиллагааг зөвхөн мэргэжлийн ёс зүй бусад шаардлагын дагуу бие даасан байдлаар явуулах нь хараат бус, төвийг сахисан сэтгүүлзүйн хэрэгслийн үндсэн нөхцөл болох ба хэвлэл мэдээллийн хэрэгсэл, үзэл суртал, ухуулга сурталчилгааны хэрэгсэл болохоос зайлсхийх боломжийг нээдэг.

Хэдийгээр сүүлийн жилүүдэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо, хэлбэрийн хувьд тасралтгүй өссөөр ирсэн ч хэвлэлийн эрх чөлөө төдийлөн хангалттай байж чадахгүй байна. Гэхдээ Монгол улс Ардчиллын зарчмыг тунхаглах болсон тэр үеэс эхлэн өдгөөг хүртэл Хэвлэлийн эрх чөлөөг хангах, хараат бус байх талаар багагүй арга хэмжээ авч, сэтгүүлчид болон судлаачид олон санал, санаачилга гаргаж байсныг энд тэмдэглэх хэрэгтэй.

1990-ээд оны эхээр шинээр гарсан хэвлэл мэдээллийн хэрэгсэл бүгд чөлөөт гэсэн тодотголтой гарч байлаа. Харин хариуцлагын тухайд орхигдуулж байжээ. Монголд чөлөөт ардчилсан олон ургальч сэтгүүлзүйг хөгжүүлэх зорилго бүхий “Хэвлэлийн хүрээлэн” 1996 онд байгуулагдсан цагаасаа хойш энэ талаар олон арга хэмжээ явуулж, судалгаа шинжилгээ сургалтын ажил эрхэлж байжээ.

“Хэвлэлийн хүрээлэн”-гээс 2004 оны тавдугаар сард орон даяар явуулсан олон нийтийн санал асуулгын дүнгээр, судалгаанд оролцогчдын 44 хувь нь монголд мэдээллийн эрх чөлөө бүрэн хангагдсан гэж үзэж байлаа¹¹. Энэ нь чөлөөт хэвлэл хөгжөөд удаагүй манай орны хувьд том дэвшил байсан хэдий ч иргэд үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах, түгээх эрх чөлөөгөө эдлэхэд хэвлэлийн эрх чөлөө маш чухал юм. Гэтэл манай олон сэтгүүлч хэвлэлийн эрх чөлөө хангалтгүй байгаа талаар ярьдаг. “Гаднаас харахад 100 хувь эрх чөлөөтэй мэт юм шиг харагдавч бид эрх чөлөөнийхөө 90 хувийг санхүүгийн дутагдлаас болж алдаж байна” гэж үзэх сэтгүүлч ч байсан юм.

“Фридом хаус” дэлхийн чөлөөт хэвлэлийн хорооноос 2000 онд Монголын хэвлэл мэдээллийг “чөлөөтэй” хэмээн үнэлсэн боловч хоёр жилийн дараа буюу 2002 онд дээрх байгууллагаас явуулсан судалгаагаар “хагас эрх чөлөөтэй” орнуудын тоонд орсноос хойш өнөөг хүртэл дээрх үзүүлэлт өөрчлөгдөөгүй ажээ.¹²

Түүнчлэн “Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний 2013 оны индекс”-ийн үзүүлэлтээр өмнөх жилийнхээс хоёр байр ухарч 98-р байранд жагссан байна. Өөрөөр хэлбэл Монгол улсад хэвлэлийн эрх чөлөө жил ирэх тусам хумигдаж байна

¹¹ “Монгол дахь мэдээллийн эрх чөлөө” (судалгааны тайлан) Хэвлэлийн хүрээлэн ТББ, \УБ 2004\,

¹² “Монгол дахь мэдээллийн эрх чөлөө” (судалгааны тайлан) Хэвлэлийн хүрээлэн ТББ, \УБ 2004\ 26-27р тал

гэсэн үг. Монгол улсын хувьд 2002 оноос тус судалгаанд хамрагдаж эхэлсэн бөгөөд 2005 онд эхний 50-д багтаж харьцангуй эрх чөлөөтэй гэгдэж байсан. Харамсалтай нь энэ үзүүлэлт жил бүр буурсаар байгаа юм.

Иргэд, олон нийт гагцхүү үнэн мэдээллийг хүртэх эрхтэй. Гэтэл бид олон нийтийн хяналт тавих нөхцлийг бүрдүүлэх, хоточ нохой байх үүргээ төдийлөн биелүүлж чадаагүй яваа нь дээрх баримтуудаас тодорхой харагдаж байна.

2006 оны тавдугаар сарын 2-нд “Глоб интернэшнл” ТББ, “Зориг сан”-гаас хамтран “Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр”-ийг тохиолдуулан цагдан хяналтын эсрэг дугуй ширээний ярилцлага зохион байгуулж,

- ✓ **УИХ, Засгийн газар, Ерөнхийлөгч, төрийн байгууллагын албан тушаалтнуудад:** “...Шууд болон шууд бус цагдан хяналтаа зогсоох, мэдээллийн эрх чөлөөний хуулийг хэлбэрэлтгүй сахих, эх сурвалжид нэвтрэх боломжийг хязгаарлахаа зогсоох, эх сурвалжаа хамгаалсан хуулийг нэн даруй батлахыг сануулсан.
- ✓ **ХМХ-ийн эзэд, эрхлэгч нарт:** Редакцийн цагдан хяналтыг хориглох, редакцийн хараат бус байдлыг хангасан гэрээг сэтгүүлчидтэй нэн даруй байгуулж, тэдний өдөр тутмын үйл ажиллагаанд дарамт шахалт үзүүлэхээ зогсоох...”,
- ✓ **МСНЭ-д** “...Хэвлэлийн эрх чөлөө, сэтгүүлчдийн эрхийг хамгаалахад амин чухал үүрэг гүйцэтгэдэг хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын тогтолцоог хөгжүүлэхэд онцгой анхаарах,
- ✓ **Сэтгүүлчдэд:** “...Мэргэжлийн эрхээ эдлэхдээ хүний эрхийг эрхэмлэн дээдэлж, мэргэжлийн ёс зүйгээ баримтлан ажиллах” зэргийг уриалсан байна.¹³

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчил 2005-2006 онд 41¹⁴, 2007-2008 онд 80¹⁵ шахам бүртгэгдсэн байгаагаас харахад энэ тоо жил ирэх тусам өсөх хандлагатай байгаа нь ажиглагдаж байна. Нөгөөтэйгүүр эдийн засаг, улс төрийн хараат байдал, эздийн ашиг сонирхол, хэвлэл мэдээллийн байгууллагын удирдлагын арга барил, мэдлэг чадвар муу байгаа нь эцэстээ редакцийн хараат байдлыг бий болгожээ. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хамгийн тулгамдаад буй асуудлын нэг бол редакцийн хараат байдал гэж манай эрдэмтэн, судлаач, сэтгүүлчид асуудал дэвшүүлж байсан нь цөөнгүй.

Тухайлбал, МУБИС-ийн МоСС-ийн Сэтгүүлзүйн тэнхмийн эрхлэгч Ж.Батбаатар “Өнөөгийн Монголын сэтгүүлзүй нь коммунист сэтгүүлзүйн арга барилаасаа бүрэн

¹³ “Глобын сонин бичиг, № 8, УБ 2007

¹⁴ “Хэвлэл мэдээллийн эрх чөлөө Монголын Үнэнгийн байдал” УБ, 2006, 12-р тал

¹⁵ “Хэвлэл мэдээллийн эрх чөлөө Монголын Үнэнгийн байдал” УБ 2007, 16-р тал

ангигирч чадаагүйн дээр санхүүжүүлэгчдээс хараат байдал давамгайлсан шинжтэй байна”¹⁶ гэжээ.

МУБИС-ийн сэтгүүлзүйн багш, доктор \Ph.D\ М.Одмандах “Орчин цагийн сэтгүүлзүй ба хараат бус байдал” өгүүлэлдээ “Манай чөлөөт хэвлэл өнөөдөр чөлөөт хэвлэл мэдээллийн гол шалгуурыг хангахгүй байгаа нь хэнд ч илт тодорхой болжээ. Монголын чөлөөт хэвлэлийн хувьд эзнээс хараат бус байдал алдагдсан. Энэ нь сэтгүүлч, ажилтны шударга, үнэнч ажиллах зарчимд нөлөөлж буй томоохон бодит хүчин зүйл мөн. Хараат бус хэвлэл мэдээллийн орчныг бүрдүүлэхдээ хэвлэл мэдээллийн хараат бус байх төрийн болон эрх зүйн орчныг судлах, эдийн засгийн орчин, ёс зүйн хариуцлагын тогтолцоог оновчтой бүрдүүлэх, редакцийн ардчиллын байдлыг баталгаажуулах”¹⁷ гэх мэт арга замууд байгааг дурьдсан байдаг.

Засгийн газрын шууд цензур байдаггүй боловч нууц эх сурвалжаа илчлэхийг шаардан албаны хүмүүс шахаж, дарамтлах, айлган сүрдүүлэх явдал байдаг хэмээн сэтгүүлчид хэлсээр байна. Тухайлбал 2007 оны хоёрдугаар сард сэтгүүлч Г.Эрдэнэтуяаг арав гаруй хүний амийг хөнөөсөн нисэх онгоцны ослын газрын зургийг авахад нь цагдаагийнхан саад хийжээ.

2007 оны зургаан сард Улаанбаатар хотын нэгэн зоогийн газрын менежер тэдний үйл ажиллагааны гэрэл зургийг авах гэсэн сурвалжлагчийг цохиж өшиглөсөн байна. Энэ халдлагыг мэдээлэхээр сэтгүүлч явж очиход орон нутгийн цагдаагийн газар түүнийг буцаажээ.

Ийнхүү нэг талаас сэтгүүлзүйд бусдаас хараат бус байх эрх чөлөөний асуудал чухал боловч нөгөө талаар бид мэргэжлийн ёсзүйн дүрэм, журмын дагуу ажиллаж байж чөлөөт, хариуцлагатай сэтгүүлзүйг хөгжүүлэх болно. Хараат бус, чөлөөт хэвлэл мэдээллийн тухай ярихдаа ёсзүйн тухай асуудлыг орхигдуулж болохгүй юм. 1980-аад оноос эхлэн дэлхийн хэвлэл мэдээллийн түүхэнд ёсзүйн хямрал болж, нийгмийн хөгжлөө дагаад анхны баталсан ёсзүйн дүрэм, журмуудыг шинэчлэх шаардлага гарсан. Энэ үеэс эхлэн Монголд ёсзүйн талаар нэлээд хүчтэй ярьж байлаа.

Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлийн хоёрдугаар их хурлаар \2005 оны 3 сарын 11\ монголын ёсзүйн зарчим баталсан. Одоогоор энэ монголын сэтгүүлчдийн ёсзүйн зарчмыг хүчин төгөлдөр мөрдөж байгаа хэдий ч бодит амьдрал дээр хэрэгжүүлэхэд нийгмийн талаас эдийн засгийн байдал, амьжиргааны түвшин, оюуны амьдрал, ёс суртахууны түвшин нийгмийн гишүүдийн итгэл үнэмшил, хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, хэвлэл мэдээллийн байгууллагын дотоод ардчилал, бүтэц зорилго, удирдлагын мэдлэг боловсрол, үзэл бодол, ашиг сонирхол, ажилтнуудын боловсрол, ёс суртахууны түвшин, сэтгүүлч, хувь хүний мэдлэг боловсрол, ёс суртахууны түвшин, санхүүгийн байдал нэлээд нөлөөтэй байна. Мөн хэвлэлийн зөвлөл байгуулах асуудал одоо болтол яригдсаар буй ч хараахан ажил хэрэг болоогүй байна.

¹⁶ Ж.Батбаатар “Сэтгүүлзүй” \УБ 2007\, 13-р тал

¹⁷ М.Одмандах “Орчин цагийн сэтгүүлзүй ба хараат бус байдал” “Сэтгүүлч сэтгүүл”, №1 \24\, УБ 2008

1.2. Редакцийн хараат бус байдлыг төлөвшүүлэхэд эрхзүйн орчин нөлөөлөх нь

Монгол Улс ардчилсан нийгэмд шилжсэнээс хойш иргэдийнхээ үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хангах чиглэлээр ач холбогдол бүхий олон арга хэмжээ авч хэрэгжүүлсний дундаас үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх зэрэг суурь эрхийг Үндсэн хуулиар баталгаажуулсан билээ. Мөн түүнчлэн Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын пакт зэрэг олон улсын гэрээ, баримт бичгийг соёрхон баталсан.

Улмаар 1998 онд Улсын Их Хурлаас Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль хэмээх 4 зүйл бүхий хуулийн заалтыг батлан гаргаж, хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээх бөгөөд төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт буюу цензур тогтоохгүй. Мөн “төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, нэвтрүүлэх мэдээлэлд хяналт тавих байгууллага байгуулахгүй бөгөөд ийм хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй, төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно” хэмээн хэвлэл мэдээллийн хэрэгслийг хувийн өмчлөлд байхаар хуульчлан баталгаажуулсан байна.

Үүний үр дүнд “Хэвлэлийн хүрээлэн”-гийн “Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр” мониторингийн судалгаагаар 2012 оны эхний хагас жилд улсын хэмжээгээр 469 хэвлэл мэдээллийн хэрэгсэлд 4415 сэтгүүлч, бусад ажилтан, албан хаагчид үйл ажиллагаагаа явуулж байна. Түүнчлэн 126 сонин, 92 сэтгүүл, 72 радио, 149 телевиз, 30 веб сайт идэвхтэйгээр ажиллаж байгаа аж.

Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16 дахь хэсэгт “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал цуглаан хийх журмыг хуулиар тогтооно” мөн 16 дугаар зүйлийн 17- д “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх , хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” хэмээн заасан нь хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийн үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн үндэс болсон байна .

Мөн олон нийтийн радио телевизийн тухай хуулийг 2005 оны нэгдүгээр сарын 27-нд баталж, энэ хуулийн тавдугаар бүлгийн нэгдүгээр зүйлд зааснаар “Олон нийтийн радио, телевизийн сурвалжлагч, редакци Үндсэн хууль болон энэ хуулийн үзэл санаанд нийцсэн нэвтрүүлэг бэлтгэх, нийтийн хүртээл болгоход нь аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн, олон нийтийн радио, телевизийн удирдлага хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно” хэмээн олон нийтийн

радио телевизийн сэтгүүлчдийн болон редакцийн хараат бус байдлыг баталгаажуулсан нь чухал зохицуулалт болжээ.

Монгол Улсын эрүүгийн хуулийн 139 дүгээр зүйлд сэтгүүлчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд саад хийх гэмт хэргийг хуульчилсан бөгөөд “Өөрийн болон бусдын ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг олон нийтэд тараах, эсхүл тараалгахгүй байхын тулд сэтгүүлчийн хуульд нийцсэн мэргэжлийн үйл ажиллагаанд саад хийсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ” хэмээн заасан бөгөөд хэрэв “энэ хэргийг албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ” хэмээн хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй хуульчилсан байна .

Монгол Улсад бусад улсын адил сэтгүүлчийн нэгдсэн ёс зүйн дүрэм хараахан байхгүй бөгөөд 2005 онд Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн 2 дугаар их хурлаас “Монголын сэтгүүлчийн ёс зүйн зарчим”- ыг баталсан боловч уг баримт бичигт редакцийн хараат бус байдлын тухай огт хөндөөгүйгээр барахгүй зарчмын төдий тунхаглалын шинжтэй. Мөн албан ёсны хяналт тавих орчин бүрдээгүй учраас хэрэгжих магадлал бага юм.

Хэдийгээр хэвлэл мэдээллийн хэрэгслийг төр хянахгүй, төрийн байгууллага хэвлэл мэдээллийн хэрэгслийг өмчлөхгүй байх талаар хуульчилж, үүний үр дүнд чөлөөт өрсөлдөөнд суурилсан хувийн хэвшил бүхий хэвлэл мэдээллийн хэрэгслүүд үйл ажиллагаагаа явуулж, төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгслийг цензурдэх байдлыг багасгасан ч нөгөө талаас сэтгүүлчдийг хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөгч, эздийн хараат байдалд оруулах, санхүүжүүлэгчийн ашиг сонирхлын үүднээс үйл ажиллагаагаа явуулах зэрэг нь манайд түгээмэл байдгийг сэтгүүлчид сануулсаар байна.

Энэ талаар судлаачид “хараат бус байдал нь эзний сонирхол сэтгүүлчийн мэргэжлийн зарчимд харшилж, редакци жижиг сажиг зүй бус явдлын тухай мэдээ, мэдээллийг сониндоо гаргуулдаг мөртлөө нийгмийн тогтолцооны гажуудал эрх мэдэлтнүүдээс хамаатай асуудлыг нийтлэхээс ихэвчлэн татгалздаг байдлаар тодотгогдоно” гэж анхааруулжээ.

Хэвлэлийн хүрээлэнгийн Мэдээллийн төвийн менежер Д.Доржхорол редакцийн хараат бус байдлын асуудлаар сэтгүүлчдийн дунд тандалт судалгаа хийсэн бөгөөд уг судалгаагаар дараах дүгнэлтүүд гарсан байна. Үүнд :

- *Нийт сэтгүүлчдийн 50 хувь нь буюу 2 сэтгүүлч тутмын нэг нь хараат бус үйл ажиллагаа явуулж чаддаггүй .*

- Өөрийн бэлтгэсэн нийтлэл нэвтрүүлгээ 54.5 хувь нь чөлөөтэй нийтэлж нэвтрүүлж чаддаггүй .
- Судалгаанд оролцсон сэтгүүлчдийн 46.3 хувь нь ХМХ - ийн эрхлэгч, редакторууд сурвалжлагч, ажилтнуудынхаа өдөр тутмын үйл ажиллагаанд мэргэжлийн шаардлага , хяналт тавьж редакцийн хараат бус байдалд халддаг .
- Нийт сэтгүүлчдийн 39 хувь нь бэлтгэсэн материалаа тухайн байгууллагын тодорхой бодлогын үүднээс нийтлэдэггүй, зарим хэсгийн хасдаг гэжээ .

“1997-2004 онд гүтгэх, доромжлохтой холбоотой нийт 75 гэмт хэрэгт бүртгэлт, мөрдөн байцаалт явуулснаас 36 эрүүгийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэсэн байна”. Энэ тал дээр судлаачид янз бүрийн бодолтой байдаг. Зарим нэг нь хүндрүүлэх заалт байхгүй бол үүнийг иргэний хэргээр шийдэж болно гэж үздэг. Нөгөөтэйгүүр сэтгүүлчдийг шүүхэд дуудахдаа хамгийн түрүүнд эх сурвалжаа илчлэхийг шаарддаг. Гэтэл өнөөдөр манайд эх сурвалжаа нууцлах хууль байхгүй. Ийм хүнд нөхцөл байдал нь сэтгүүлчдийг өөртөө хяналт тавих буюу өөрийн цензур рүү түлхэж байгаа юм.

Тиймээс 2006 оны 03 сарын 13-нд Олон Улсын Сэтгүүлчдийн Холбооноос “Монгол улсад засаг захиргааны ажилтнууд сэтгүүлчдийг цагдан хянаж, сүрдүүлсэн нэлээд хэдэн хэрэг гарсантай холбогдуулан Олон Улсын Сэтгүүлчдийн Холбоо “монголын сэтгүүлчид хуулийн илүү таатай орчинд ажиллах ёстойг анхааруулан мэдэгдэж байна. Сэтгүүлчдийг энэхүү дарамт шахалтаас ангижруулж, улмаар эх сурвалжаа нууцлах явдлыг хуульчлан баталж өгөхийг бид монголын эрх баригчдад хандан уриалж байна” гэсэн мэдэгдэл гаргажээ.

Чөлөөт сэтгүүлзүйн тухай ярилгүйгээр редакцийн хараат бус байдлын талаар ярих боломжгүй юм. Дэлхийн чөлөөт хэвлэлийн хороо “Фридом хаус” www.freedomhouse.org цахим хуудаст Монголын хэвлэл мэдээллийг дүгнэжээ.

“Монгол улсад үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө хуулиар хамгаалагдсан ба засгийн газар нь энэ эрхийг ерөнхийдөө бодитойгоор хүндэлдэг. Гэвч сэтгүүлчдийн эсрэг өөр бусад хуулиар дарамт шахалт учруулдаг, мөн сэтгүүлчдэд тулгарсаар байгаа санхүүгий хүндрэлийн улмаас 2007 онд хэвлэлийн эрх чөлөө үл ялиг зөрчигдсэн. 1998 онд баталсан Хэвлэлийн эрх чөлөөний хуулиар олон нийтийн мэдээлэлд цензур тавихыг хориглосон боловч Улсын нууцын хуулиар төрийн мэдээлэл нь архивт хадгалагддаг, түүхэн баримтуудынхтай адилхан хэмжээний нууцын зэрэгтэй юм.

Хараат бус хэвлэл мэдээллийг хөгжүүлэх, дэмжих талаар дэлхийн олон оронд тодорхой үйл ажиллагаа явуулдаг. Үүний нэг жишээ нь “**Чөлөөт хэвлэлийн харти**”-г батлан гаргасан явдал юм. “Чөлөөт хэвлэлийн харти”-г 1987 оны нэгдүгээр сарын 16-18-ны өдрүүдэд Лондон хотноо болсон “Дэлхийн эрх чөлөөний дуу хоолой” цагдан хяналтын эсрэг бага хурлын төлөөлөгчид болох 34 орны сэтгүүлчид

баталжээ. Энэхүү бага хурлыг Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний хороо \WPFC\, Олон улсын хэвлэн нийтлэгчдийн холбоо \FIEJ\, Олон улсын хэвлэлийн хүрээлэн \PI\, Америк дундын хэвлэлийн эвлэл \IAPA\, Хойд Америкийн өргөн нэвтрүүлэгчдийн эвлэл \NANBA\, Олон улсын тогтмол хэвлэлийн холбоо \IFPP\ хамтран зохион байгуулжээ.

Хэвлэлийн эрх чөлөөний харти нь чөлөөт, хараат бус хэвлэл мэдээллийг дэмжихэд зайлшгүй хамгийн түгээмэл зарчмуудыг агуулсан баримт бичиг юм. Хэвлэлийн эрх чөлөөний харти-д заасан зарчмыг 1989, 1991 онуудад Лондон, мөн 1991 онд Москва хотноо Хэвлэл мэдээллийн асуудлаар болсон чуулга уулзалт, дугуй ширээний ярилцлага, 1991 онд Норвеги улсын Осло хотод болсон Ардчилсан байгууллагуудын шинжээчдийн зөвлөлгөөнөөр хүлээн зөвшөөрсөн байна.

Тус хартийн зургаадугаар зарчимд “Засгийн газрын хэвлэл мэдээллийн хэрэгсэлд редакцийн хараат бус байдлыг эрхэмлэх, янз бүрийн үзэл бодлоо илэрхийлэхэд нээлттэй байх ёстой. Үүнийг эрхзүй, практикийн хүрээнд баталгаажуулбал зохино” гэж заасан байдаг.

Харин энэхүү харти-г Монгол улсад анх 1996 онд тухайн үедээ Монголын Чөлөөт Ардчилсан Сэтгүүлчдийн Эвлэлийн ерөнхийлөгч байсан Ц.Дашдондов орчуулсан бөгөөд энэ үйл явдал нь монголд чөлөөт хэвлэл төлөвшихөд тодорхой хувь нэмэр оруулсан гэж болно.

Редакцийн хараат бус байдлыг төлөвшүүлэх талаар сэтгүүлзүйн хөгжлийн янз бүрийн төвшинд хүрсэн улс орнууд ижил төстэй арга зам эрэлхийлж, хэрэглэж иржээ. Тухайлбал Италийн сэтгүүлчдийн “Федерасион Националь Делла Стампа” байгууллагын үзэж буйгаар *“Хэвлэлийн үүрэг, эдийн засаг улс төрийн аль нэг эрхтэн дархтаныг дэмжихэд бус харин уншигчдынхаа тусын тулд нийгэм, түүн доторх эрх мэдэл бүхий хүмүүсийн талаар өдөр тутам иж бүрэн дүр зургийг нээн харуулахад оршино”* гэжээ.

Сэтгүүлзүй өндөр хөгжсөн орнуудад редакцийн хараат бус байдлыг хангах нийгмийн урьдчилсан нөхцлийг бүрдүүлэхийн тулд дараах хүчин зүйлсэд онцгой анхаардаг байна. Үүнд:

- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг эрхзүйн хувьд баталгаажуулсан байх
- Эрх зүйт төрийг бэхжүүлэх \төрийн дарангуйллаас урьдчилан сэргийлэх, шүүх эрх мэдэл, хууль эрхзүйн орчин\
- Ардчилсан нийгэм, түүний үнэт зүйлсийг төлөвшүүлэх
- Хэвлэл мэдээллийн олон ургальч систем, нээлттэй чөлөөтэй зах зээлийг хөгжүүлэх зэрэг асуудал юм.

АНУ - ын Дээд шүүх нь 1972 онд Уетергейтын хэргийг шийдвэрлэж байсан нь манай орон шиг хуулийн дагуу асуудлыг шийдвэрлэхдээ хойрго хүмүүст үлгэр жишээ болохоор үйл явдал юм. Энэ хэргийн гол утга нь тухайн үед ерөнхийлөгч байсан

Ричард Никсон өөрийн бүрэн эрхийн хугацаандаа эсрэг намын нөхдийн үйл ажиллагааг тагнан мэдээлэл авсан нь “Нью - Йорк Таймз” сонины сэтгүүлчдийн гарт орж, хэвлэн нийтлэснийг улсын нууц задруулсан хэмээн буруутгаж цагдаагийн байгууллагад өгсөн. АНУ - ын Дээд шүүх уг хэргийг хянаад “АНУ - ын Үндсэн хууль нь иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг баталгаажуулсны зэрэгцээ хэвлэл мэдээллийн байгууллагад төрийн нууцыг хамгаалах үүрэг ногдуулаагүй байна.”¹⁸

“Сэтгүүлчдийн эрхийг сайн хамгаалсан” гэх тодотголтой Европын эх газрын төлөөлөл болох Швейцар, Герман, Португали болон Скандинавын эрх зүйн бүлд хамаарах Норвеги, Исланд, Швед зэрэг улс орон эрхзүйн зохицуулалт хэрхэн хийдэг болохыг авч үзье.

1. Холбооны бүгд найрамдах Швейцар улс

Швейцарийн холбооны улсын хувьд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбоотой харилцааг тусгайлсан хууль болох “Телевиз, радионы тухай хууль”-иар зохицуулдаг байна. Тухайн хууль нь 6 бүлэг, 113 зүйлээс бүрдэх томоохон хууль бөгөөд сэтгүүлч түүний хараат бус, бие даасан байдлыг хуулийн 1 дүгээр бүлгийн 4 дүгээр зүйл буюу Хэвлэлийн байгууллагын үйл ажиллагааны зарчим хэсэгт хуульчилжээ. “Аливаа радио, телевизийн нэвтрүүлэг нь хүний суурь эрх чөлөөг хүндэтгэн, арьс өнгөөр ялгаварлан гадуурхалгүй, нийтийн ёс зүй, амар тайван байдалд нийцсэн байна” хэмээн хуульчилсан нь аливаа хэвлэл мэдээллийн хэрэгслийн хэвлэн нийтлэх эрхийн хүрээг тодорхойлж өгчээ. Харин тус хуулийн 6 дугаар зүйлд “сэтгүүлчийн хараат бус, бие даасан байдал”-ын талаар хуульчилсан бөгөөд Хуулийн 6.1 дэх хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол аливаа төрийн байгууллага нь сэтгүүлчид болон хэвлэлийн байгууллагын үйл ажиллагаанд оролцохгүй”, 6.2 дахь хэсэгт “сэтгүүлч нь өөрийн программ, нэвтрүүлгийн утга, агуулгыг өөрөө сонгох эрхтэй бөгөөд дээрх мэдээлэлтэй холбоотой асуудлыг хариуцна” хэмээн хуульчилжээ .

Мөн хуулийн 12 дугаар зүйл 12.1 дэх хэсэгт “захиалгат нэвтрүүлгийн утга, агуулгатай холбоотой хариуцлагыг тухайн хэвлэлийн байгууллага хариуцах бөгөөд захиалагч болон санхүүжүүлэгч нь редакцийн бие даасан байдалд нөлөөлөхүйц байдлаар оролцохгүй” гэжээ. Эндээс харахад сэтгүүлч нь өөрсдийн хариуцсан мэдээ, нийтлэлийн утгыг хэн нэгнээс хараат бусаар, бие даан шийдэх эрхтэй байхаар хуульчлан баталгаажуулжээ. Мөн үүний зэрэгцээ сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагааг санхүүжүүлэгчээс хамгаалсан байна.

¹⁸ М . Батсуурь . Эрх чөлөөг гагцхүү зүй ёсны хуулиар хязгаарлаж болно . “ Шихи - хутуг ” сэтгүүл . УБ ., 2006 он .

Швейцарийн холбооны улсын хувьд сэтгүүлчийн бие даасан, хараат бус байдлын талаар хуулиар зохицуулахаас гадна “Сэтгүүлчийн эрх ба үүргийн тунхаглал” гэх баримт бичгээр дэлгэрэнгүй зохицуулдаг байна.

2. Холбооны Бүгд Найрамдах Герман улс

Үндсэн хуулийнхаа тавдугаар зүйлд хэвлэн нийтлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулсан байдаг ба үүнээс эх авсан Хэвлэл мэдээллийн тухай хууль нь 24 зүйлээс бүрдэнэ. Тус хуульд хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулахдаа “хэвлэл нь чөлөөтэй хэвлэн нийтлэх эрхтэй хэмээн нэн тэргүүнд тусгаснаас гадна үүнийгээ ардчилал эрх чөлөөний суурь мөн” хэмээн тайлбарлажээ. Харин тус улсын “Сэтгүүлчийн ёс зүйн дүрэм” нь 1993 онд Сэтгүүлчдийн холбооноос батлагдсан бөгөөд нийт 10 зүйлтэй. Дүрмийн 3 дугаар зүйлд “Сэтгүүлч нь мэдээллийн эрх чөлөө болон хэвлэн нийтлэх эрх чөлөөг хязгаарласан үйлдэлтэй тэмцэж энэхүү үйлдлүүдийг нийгэмд мэдээлэх үүрэгтэй”. Дүрмийн 10 дугаар зүйлд “Сэтгүүлч нь өөрийн мэргэжлийн ёс зүй, хараат бус, бие даасан байдалд нөлөөлөхүйц хүсэлт, бэлэг хүлээн авахаас татгалзах үүрэгтэй. Сэтгүүлч нь өөрийн байр сууриа хувийн ашиг сонирхолдоо ашиглаж болохгүй” гэж тус тус зохицуулсан байна .

3. Исланд улс

Тус улсын хувьд 2000 оны тавдугаар сард батлагдсан “Радио, телевизийн тухай хууль” нь өөрийн улсад цацагдаж буй радио, телевизийн үйл ажиллагаа, тусгай зөвшөөрөл, радио, телевизийн тусгай зөвшөөрөл олгох хороо, түүний эрх хэмжээ, зар сурталчилгаа, ивээн тэтгэгчийн эрх үүрэг, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага зэрэг өргөн харилцааг зохицуулж байна. Тус хууль нь 12 бүлэг, 37 зүйлээс бүрдсэн бөгөөд сэтгүүлч, редакцийн хараат бус, бие даасан байдлыг тусгайлан зохицуулсан зүйл байхгүй байна. Хуулийн 21 дүгээр зүйлд “радио, телевизийн байгууллага нь тусгайлсан нэвтрүүлгийг ивээн тэтгэгчтэйгээр явуулж болох бөгөөд ивээн тэтгэгч нь программ, нэвтгүүлгийн утга, агуулга, хэвлэлийн байгууллагын хариуцлага болон бие даасан байдалд нөлөөлөхгүй” гэсэн ганцхан зохицуулалт оржээ.

4. Норвеги улс

Тус улс нь 1814 онд батлагдсан Үндсэн хуулийн 100 дугаар зүйлд “Хэвлэл мэдээлэл нь чөлөөтэй байна. Мэдээ, мэдээллийн утга нь хууль зөрчсөн, шашин, шүтлэг, нийгмийн ёс журмыг үл хүндэтгэсэн, аливаа этгээдийн нэр хүндэд халдсан, худал хуурмаг мэдээлэл цацсанаас бусад тохиолдолд хэвлүүлсэн болон хэвлүүлэхээр бэлтгэж буй этгээдэд хариуцлага ногдуулахыг хориглоно” хэмээн анх удаа хэвлэлийн эрх чөлөөг хуульчилсан байна. Дээрх Үндсэн хуулиас гадна тусгайлан хэвлэл мэдээлэлтэй холбоотой харилцааг зохицуулахаар 1997 онд батлагдсан 11 бүлгээс бүрдэх “Радио, телевизийн тухай хуулиар” хэвлэл мэдээллийн харилцааг зохицуулдаг бөгөөд тус хуулинд редакцийн бие даасан, хараат бус байдлын тухай дурьдсан зохицуулалт хараахан байхгүй байна.

Мөн тус улсын “Сэтгүүлчийн ёс зүйн дүрэм”- ийг 2007 оны 11 дүгээр сард “Норвегийн сэтгүүлчдийн холбооноос” батласан бөгөөд Сэтгүүлч, редакцийн хараат бус, бие даасан байдлын талаар дүрмийн 2.2 дахь хэсэгт “Сэтгүүлч, редакци нь өөрсдийн бие даасан, хараат бус ажиллах нөхцөл бололцоогоо аливаа гуравдагч этгээд, хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаанд нөлөөлөхийг хүсэж буй этгээдээс хамгаалах үүрэгтэй” гэжээ .

5. Швед Улс

Тус улс нь сэтгүүл зүй, хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой харилцааг “Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулиар” зохицуулдаг бөгөөд энэ нь 14 бүлэг, тус тусын зүйлээс бүрдсэн томоохон хууль юм. Тус хуулинд сэтгүүлчийн мэдээлэл авах эрх болон хэвлэлийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийг тусгайлан зааж, зөрчсөн тохиолдолд хэн, хэрхэн хариуцлага ногдуулах талаар тусгасан байна. Харин сэтгүүлч, редакцийн хараат бус байдлын талаар зарим улстай харьцуулахад анхаарал татах заалт цөөнгүй харагдсан юм. Үүнд хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт **“Хэвлэлтээс өмнө ямар ч зүйлийг үл хянан шалгах ба ямар ч зүйлийн хэвлэлийг үл хориглоно”** гэсэн зохицуулалтанд хэвлэлийн байгууллагын бие даасан байдал, өөрсдийн эрх хэмжээний хүрээнд мэдээ, материалыг нийтлэх эрхийг хуульчилсан гэж үзэж болохоор байна .

Мөн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт “Цаашлаад ямар ч засаг захиргааны төв байгууллага болон аливаа төрийн байгууллагын зүгээс хэвлэгдсэн зүйлийг үндэслэн энэхүү хуульд зааснаас өөр хэлбэрээр арга хэмжээ авахыг хориглох ба тухайн материалыг хэвлэн нийтлэх, олон нийтэд тараахад саад болохыг хориглоно” гэж заасан нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээ, материалд үндэслэн тухайн хуульд зааснаас бусад тохиолдолд редакцийн үйл ажиллагаанд төрийн байгууллагын зүгээс оролцохгүй, бие даасан хараат бус байдалд халдахгүй байхыг баталгаажуулжээ. Мөн хуулийн 5 дугаар бүлгийн 3 дугаар зүйлд зааснаар “Тогтмол хэвлэлийн хариуцлагатай эрхлэгчийг хэвлэлийн эзэн томилно. Хариуцлагатай эрхлэгчийн үйл ажиллагааны хүрээнд тогтмол хэвлэлийн хэвлэлтийг хариуцан хангах, түүний хүслийн эсрэг ямар ч зүйл хэвлэгдэхгүй байхаар агуулгыг тогтоон тодорхойлох эрх багтана. Хариуцлагатай эрхлэгчийн эдгээр эрхийг хязгаарлах ямарваа хязгаарлалт нь хууль бус ба хүчингүй байна” гэж заажээ. Эндээс үзэхэд хариуцлагатай эрхлэгч буюу ерөнхий редакторын үйл ажиллагааны бие даасан, хараат бус байдлыг тусгайлан хуульчилжээ.

6. Оросын Холбооны улс

Оросын холбооны улсын хувьд хэвлэл мэдээллийн харилцааг бүхэлд нь “Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тухай хуулиар” зохицуулдаг. Энэ хууль нь 62 зүйлээс бүрдэх бөгөөд хэвлэлийн эрх чөлөө, түүний бүтэц, сэтгүүлчдийн зөвлөл, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тусгай зөвшөрөл гэх мэт өргөн агуулга бүхий хууль байна. Тус хуулийн 3 дугаар зүйлд “Олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд төрийн болон олон нийтийн байгууллага, бүлэглэл, бусад байгуулал, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хяналтын алба зэргээс аливаа цензур нөхцөл тогтоох, хэвлэх материалыг дэлгэрүүлэх, аливаа хэсгийг хасах зэргийг хориглоно”. Мөн

“Аливаа байгууллага, алба бусад байгуулалыг санхүүжүүлэхдээ олон нийтийн мэдээллийг цензурдэхыг хориглоно” гэжээ. Энэ хуулийн зохицуулалт нь хэвлэл мэдээллийн хэргэслийг санхүүжүүлэгч, хамтран ажиллагсад болон байгууллагат зориулсан зохицуулалт бөгөөд редакцийн эдийн засгийн хараат бус байдлыг баталгаажуулсан гэж болохоор байна .

Мөн хуулийн “Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн үүсгэн байгуулагч хэмээх” 2 дугаар бүлгийн 18 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Үүсгэн байгуулагч нь энэ хууль, хяналтын албанаас гаргасан дүрэм, гэрээнд зааснаас бусад байдлаар мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаанд оролцохыг хориглоно” хэмээн зохицуулжээ. Энэхүү заалт нь сэтгүүлч, редакци болон тухайн хэвлэл мэдээллийн хэрэгслийн удирдлагын хоорондын харилцааг зохицуулж, сэтгүүлчийн редакцийн хараат бус байдлыг бий болгосон давуу талтай байна .

Дээрх зүйлээс гадна сэтгүүлч , редакцийн хувийн эрх хэмжээг мөн хуулийн 47 дугаар зүйлд зохицуулсан бөгөөд 47 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт “өөрийн итгэл, үнэмшилд нийцэхгүй мэдээ, мэдээллийг өөрийн нэрээр гаргахаас татгалзах”, мөн 11 дэх хэсэгт “өөрийн бэлтгэсэн мэдээ, мэдээлэлд ямар нэгэн байдлаар засвар орсон, бүлэг, хэсгийг хассан, хориглосон бол өөрийн нэрээр гаргахаас татгалзах эрхтэй” хэмээн хуульчилжээ. Дээрх зүйлийн дагуу аливаа сэтгүүлч нь өөрийн тухайн мэдээллийг бэлтгэсэн анхны хүсэл, зоригт нийцээгүй, удирдлага болон бусад этгээдийн зүгээс их, бага хэмжээгээр засвар орсон, хассан, хувийн хараат бус, бие даасан байдалд халдсан хэмээн үзсэн бол тухайн мэдээ, нийтлэлийг өөрийн нэрээр гаргахаас татгалзах эрхтэй гэсэн байна. Энэ нь тухайн сэтгүүлч, редакци нь өөрийн итгэл, үнэмшилтэй байх, бие даасан, хараат бус байх нөхцлийг хангаж өгчээ.

7. Бүгд найрамдах Македон улс

Тус улсын Радио, телевизийн тухай хууль нь 8 бүлэг, 93 зүйлээс бүрдэнэ . Агуулгын хувьд редакцийн хараат бус байдал болон радио, телевизийн байгууллагын үйл ажиллагааг маш нарийн зохицуулсан бөгөөд хуулийн хэрэгжилтийг Харилцаа холбооны яам, Улсын мэргэжлийн хяналтын байгууллага болон Радио, телевизийн Зөвлөл хариуцан ажилладаг юм байна. Улс төрийн нам, эвсэл болон бусад хувь хүний зорилгыг биелүүлэх үүднээс ажиллахгүй байх ёстой хэмээн заажээ. Түүнчлэн хуулийн 59 дүгээр зүйлд “аливаа программ , нэвтрүүлгийг ивээн тэтгэгч нь редакцийн бие даасан, хараат бус байдал болон хариуцлагад нөлөөлөх замаар программ, нэвтрүүлгийн утга, үргэлжлэх хугацаанд нөлөөлөхгүй” байх хэрэгтэй хэмээн тусгажээ.

8. Гурж улс

Гурж улсын Радио, телевизийн тухай хууль 2004 онд батлагдсан бөгөөд 11 бүлэг, 77 зүйлээс бүрдэнэ. Тус улсын Радио, телевизийн хуульд редакцийн хараат бус байдлын тухай тодорхой зохицуулалтууд хийгджээ. Тухайлбал хуулийн 16 дугаар бүлэгт редакцийн хараат бус болон нэвтрүүлгийн шударга, олон ургалч байдлыг баталгаажуулж, төр, улс төрийн хүчин, шашин болон арилжааны дарамт шахалтаас ангид байна”, 16.1-т “радио, телевизийн аливаа хараат бусаар бэлтгэсэн

нэвтрүүлэг нь нэвтрүүлгийн цагийн 25%- иас доошгүй байна” хэмээн радио, телевизийн байгууллагуудын үүрэгт редакцийн хараат бус байдлыг баталгаажуулжээ . Мөн хуулийн 18 дугаар зүйлд Олон нийтийн радио, телевизийн хараат бус байдал ба дархлааны тухай зохицуулсан байна. Үүнд “Олон нийтийн радио, телевиз, түүний удирдлага болон ажилтнууд нь үйл ажиллагаагаа хараат бусаар явуулж, гагцхүү хуульд захирагдана. Тэдний үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлж, оролцсон үйлдэл нь хариуцлагад татагдана” хэмээн заажээ.

Дээрх улс орнуудын жишээнээс харахад манай оронд хэрэгжиж, хуулинд хараахан тусгагдаагүй байгаа хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой дэвшилтэт зохицуулалтууд олон байна. Манай улсын хувьд олон нийтийн радио, телевизээс бусад хэвлэл мэдээллийн хэрэгсэл дэх редакцийн хараат бус байдлыг баталгаажуулсан хууль байхгүй учир өмчлөгч болон редакци, сэтгүүлчийн хоорондын харилцаа хуулийн зохицуулалтгүй үлджээ. Иймээс өмчлөгчөөс сэтгүүлчийн үйл ажиллагаанд хутгалдан орох, хяналт тавих, цензурдэх боломж нээлттэй бөгөөд ихэнх телевиз нь ямар нэгэн улс төрч, бизнесмений өмч, улмаар зөвхөн тухайн хүний үйл ажиллагааг сурталчилж, иргэдэд хэт нэг талыг барьсан, бодит бус мэдээллийг тараах явдал түгээмэл байна .

Өөрөөр хэлбэл тухайн байгууллагад ажиллаж буй сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан нь зөвхөн удирдлагаас зөвшөөрсөн, зааварчилсан мэдээллийг нийтэлж, ингэснээр өөрсдийн мэргэжлийн үйл ажиллагааг хараат бусаар явуулах боломж хязгаарлагдсан байна. Түүнчлэн Монгол улсад хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоог зохистой хангах төрийн бодлого хангалтгүй учраас тооны тэнцвэрт байдал алдагдаж, хэтэрхий олон хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй болсон нь жижиг зах зээл дээрээс санхүүжилт босгох хүндхэн даалгаварт унагаж буй юм. Хэвлэл мэдээллийн байгууллагад өөрийгөө санхүүжүүлэх боломж хомсдохын хирээр тогтмол санхүүжүүлэх байгууллага, улс төрийн хүчний эрхшээлд орох, худалдагдах байдал түгээмэл болох нь тодорхой. Санхүүгийн хомсдол нь сэтгүүлчдийг мэргэжлийн үйл ажиллагаанаас нь илүүтэй бизнес мэдээнд төвлөрүүлэх, эздийн эдийн засгийн болон улс төрийн сонирхол редакцийн мэргэжлийн үйл ажиллагаанд хутгалдан орох үндэс болж байгааг үгүйсгэх аргагүй.

Хэвлэлийн эрх чөлөө харьцангуй хөгжсөн улсуудын эрх зүйн зохицуулалтыг аваад үзэхэд хэвлэл мэдээллийн байгууллагын эрх зүйн байдал, үйл ажиллагаа, тодорхой мэдээлэл нэвтрүүлэх журам болон улс төрийн болон эдийн засгийн хараат бус байдлыг хангах зохицуулалтын зэрэгцээ сэтгүүлчийн мэдээлэл хайж олох, эх сурвалжаа нууцлах зэрэг асуудлуудыг зохицуулсан боловч хэвлэл мэдээллийн байгууллагын өмчлөгч, эздээс редакци хараат бус байх тухай редакцийн хараат бус байдлын шууд тусгайлан зохицуулсан хэм хэмжээ байхгүй байна. Мөн редакцийн хараат бус байдал болон байгууллагын эзэн, ажилтны хоорондох асуудлыг зохицуулах уламжлалт соёл , туршлага ч манайд алга байна.

Тиймээс энэ бүгдийг хангаж, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, редакцийн хараат бус байдлыг зохицуулах хуулийн төслийг Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 2011 онд УИХ-д өргөн барьсан ч буцаан татсан юм. Төслийг улс төрийн шалтгаан болон сэтгүүлчийн мэдрэмж гэсэн хоёр зүйлээс болж татжээ. Учир нь “Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль”-ийн төслийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2, 8.3 заалтууд үйл

ажиллагаагаа явуулж буй хэвлэл мэдээллийн редакциудын эрхийг ноцтой зөрчсөн хэмээн эздүүд үзсэн юм.

“8 дугаар зүйл. Редакцийн бие даасан хараат бус байдлыг хангах

- 8.1 Хэвлэл мэдээллийн байгууллагын редакц тухайн хэвлэл мэдээллийн байгууллагын үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагч, хувь эзэмшигч нарын ашиг сонирхлоос хараат бусаар бие даасан үйл ажиллагаа явуулна.
- 8.2 Хэвлэл мэдээллийн байгууллагын үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагч, хувь эзэмшигч редакцийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох нөлөөлөхийг хориглоно.
- 8.3 Хэвлэл мэдээллийн байгууллагын редакцийн эрхлэгч үүсгэн байгуулагч эсвэл эзэмшигчтэй хараат бус байдлыг хангах гэрээ байгуулна..... гэсэн энэхүү заалт нь хэвлэл мэдээллийн хөрөнгө оруулагч, эздийг редакциас нь тусгаарлаж, тэдний оронд улс төрчид болон улс төрийн намууд сэтгүүлчдийг хямдханаар худалдан авч нөлөөлөлдөө оруулах боломжийг бүрдүүлжээ. Өнгөц харахад редакцийн хараат бус байдал хэмээх сайхан үгэнд дулдуйдсан заалт мэт боловч ачир дээрээ монголын хэвлэл мэдээллийн хэрэгслийг харсан зүгтээ залахыг хүсдэг улстөрчдийн ашиг сонирхол дор сул хаяж өгөх хуулийн цоорхойг нээж өгчээ.¹⁹

Ийнхүү хэвлэл мэдээллийн эздийн нэгдсэн холбоод эдгээр заалтыг эсэргүүцэж мэдэгдэл гаргасны үндсэн дээр хуулийг дахин шинэчлэн хэлэлцэхээр болсон юм.

Шинэчилсэн найруулгын 8-р заалтын хувьд:

8-р зүйл. Хэвлэл мэдээллийн байгууллагын редакцийн бие даасан, хараат бус байдал

8.1. Хэвлэл мэдээллийн байгууллагын редакц нь тухайн хэвлэл мэдээллийн байгууллагын үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгч, хувьцаа эзэмшигч нарын ашиг сонирхлоос хараат бусаар бие даан үйл ажиллагаа явуулна.

8.2. Хэвлэл мэдээллийн байгууллагын үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгч, хувцаа эзэмшигч нь редакцийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно.

8.3. Хэвлэл мэдээллийн байгууллагын редакцийн эрхлэгч нь үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгч, хувьцаа эзэмшигчтэй хараат бус байдлыг хангах талаар гэрээ байгуулна.

8.4. Нийтлэл нэвтрүүлгийн ивээн тэтгэгч, санхүүжүүлэгч тухайн нийтлэл, нэвтрүүлгийн агуулгад нөлөөлөхийг хориглоно... хэмээн өөрчилжээ.

Хэвлэлийн эрх чөлөөний хуулийн шинэ төсөл дээр голлон ажиллаж буй УИХ-ын гишүүн М.Батчимэг “Энэ хууль УИХ-аар хэлэлцэгдэж байгаад зогссон шалтгааны нэг бол хэвлэл мэдээллийн салбарын зүгээс тодорхой хэмжээний эргэлзээ илэрхийлсэн.

¹⁹ “Завгуй” Л.Болормаа \Хэвлэл менежментийн практик звллг\ 136-р тал, УБ 2013

Тийм учир энэ салбарынхан өөрсдөө хариуцлагыг бий болгох, хуулиа батлах нэгдмэл уур амьсгал, ойлголтод хүрсэн цагт Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль батлагдах үндэс суурь бүрдэх юм” хэмээн 2013 оны аравдугаар сарын 4-ний өдрийн Төрийн ордонд чуулсан Хэвлэл мэдээллийн удирдах ажилтнуудын үндэсний 2-р чуулган дээр хэлсэн юм.

Түүнчлэн улс төрчид энэхүү хуулийн төслийн талаар өөрсдийн үзэл бодлоо илэрхийлжээ. Тухайлбал: УИХ-ын дарга З.Энхболд:

“Эзэд, редакци хоёр нэг болсон хэвлэл, мэдээллийн байгууллага олон байгаа. Хөрөнгө оруулагч үйл ажиллагаанд оролцохгүй байна гэж байхгүй. Тийм учраас энэ бүхнийг маш сайн судалж дахин нягтлах ёстой. Нөгөө талаас сэтгүүлч тухайн асуудлаар юм бичих, ядаж мэдээлэлд нь багтаж байгаа хүнээсээ тодруулж асуудлыг бичих ёстой. Ингээгүй тохиолдолд Хэвлэлийн консулд нь ханддаг байх гээд олон асуудлыг цэгцлэх хэрэгтэй” гэжээ.

УИХ-ын гишүүн Ж.Энхбаяр “Нийт хэвлэл мэдээллийн хэрэгслэлийн хөрөнгө оруулагчдын 99 шахам хувь нь улстөрчид байгаа. Тэдний олонх нь энэ УИХ-д байна. Тиймээс хөрөнгө оруулагч буюу эзэд, сэтгүүлчид, эрхлэгч нарыг тус тусад нь оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулсны дараа хуулийн төслийн хэлэлцүүлгийг үргэлжлүүлэх ёстой” гэсэн байр суурийг илэрхийлжээ.²⁰

Харин ерөнхийлөгчийн зөвлөх Ч.Сосормаа “Наймдугаар заалтыг татсанаараа хуулийн гол үзэл санаа алдагдсан гэж үзэхгүй байна” гэсэн тайлбар хийжээ.

Ийнхүү хэвлэлийн эрх чөлөөний хууль нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн хараат бус байдлыг хангах нөгөө талаас хариуцлага хүлээдэг, ёс зүйгээ баримталдаг хэвлэл мэдээллийн хэрэгслийн ажил үүргийг тусгаж өгсөн гол агуулгатайгаар шинэчлэгдэн найруулагдсан бөгөөд одоогоор хэлэлцэгдэх шатандаа явж байна. Тухайлбал төрийн статустай хэвлэл, мэдээллийн байгууллагад нөлөөлөх нөлөөллийг хязгаарласан заалтуудыг түлхүү оруулжээ. Нөгөөтэйгүүр хэвлэл мэдээллийн хэрэгслийн хөрөнгө оруулагчид болон үүсгэн байгуулагчдыг ил зарлах зохицуулалтыг тусгаж өгсөн байна. Сэтгүүлчдийн хараат бус байдлыг баталгаажуулахын тулд эзэн буюу редакци нь сэтгүүлчтэйгээ хараат бус байдлын гэрээ байгуулж, түүнийгээ дотоод дүрэм, журамдаа тусгаад явах зарчмын зохицуулалтыг оруулжээ. Энэ хуулийг баталснаар гутаан доромжилсон гэдэг үндэслэлээр сэтгүүлчдэд эрүүгийн хэрэг үүсгэдэг асуудлыг хүчингүй болгохоос гадна хэвлэл мэдээллийн эрх чөлөө хараат бус байдал болон иргэн хүний мэдээлэл авах эрх чөлөөнд маш том ахиц болохоор тусгагджээ.

Хэвлэл Мэдээллийн Эрх Чөлөөний тухай энэхүү хуулийн шинэчилсэн найруулга батлагдвал Редакцийн хараат бус байдал болон иргэдийн мэдээлэл авах эрхэд ямар ач тустай болох тухай сэтгүүлчид ийнхүү ярьж байна.

Монголын үндэсний олон нийтийн телевизийн ММ агентлагийн тоймч, Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг

^{20 20} “Завгэй” Л.Болормаа \Хэвлэл менежментийн практик зөвлөгөө\ 139-р тал, УБ 2013

хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсгийн гишүүн Ж.Алтангэрэл:

- Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг УИХ анх 1998 онд баталж гаргаж байсан. Тухайн үед чөлөөт хэвлэлийн гол суурь зохицуулалтуудыг хийж чадсан. Тухайлбал, төр өөрийн эзэмшилдээ хэвлэл, мэдээллийн хэрэгсэлтэй байх ёсгүй. Төрийн зүгээс хэвлэл, мэдээллийн байгууллагын мэдээллийн агуулгад хяналт тавихгүй байх. Хяналт тавьдаг байгууллагыг санхүүжүүлэхийг хориглоно гэх зэрэг гол суурь зохицуулалтыг хийсэн.

Гэхдээ сүүлийн жилүүдэд хэвлэл, мэдээллийн байгууллагын тоо нэмэгдэж байна. Үйл ажиллагааны агуулга, чиглэл нэлээд өргөн цар хүрээтэй болж байна. Эрх зүйн хүрээнд зохицуулалт шаардсан, тодорхой болгох асуудал нэлээд хуримтлагдсан. Энэ бүхнийг харгалзаж Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг зайлшгүй шинэчлэх, эрх зүйн шинэ орчин бүрдүүлэх шаардлага үүссэн гэж ойлгож байгаа.

Энэ хүрээнд яригдаж буй гол асуудал бол нэгдүгээрт, хэвлэлийн эрх чөлөөг тунхаглах ёстой. Хоёрт, хэвлэл, мэдээллийн байгууллагын ил тод байдал, хариуцлагатай холбоотой асуудлыг зохицуулах ёстой. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өргөн барьсан хуулийн төслийн гол үзэл баримтлал ч үүнд чиглэж байна.

Хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулах хамгийн гол зүйл бол хараат бус байдлыг хангах явдал гэж аль аль талдаа хүлээн зөвшөөрч байгаа. Хэвлэл, мэдээллийн байгууллага, редакцийн төвшинд хараат бус байдлыг яаж хангах вэ гэдэгтэй холбоотой асуудлууд хуулийн төсөлд нэлээд туссан байна.

Монголын үндэсний олон нийтийн радиогийн “Хурд” агентлагийн тоймч С.Мөнгөнтуяа:

-УИХ-аас 1998 онд баталсан Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль хэдийгээр ганц хуудсанд багтах жижиг хууль байсан ч тухайн үед хэвлэл, мэдээлэлтэй холбоотой асуудлыг зохицуулж, хэвлэлийг төрөөс хараат бус болгоход үүргээ гүйцэтгэсэн гэж үздэг. Өнөөдөр нийгмийн хөгжил цаг хугацаатай уралдан шинэчлэгдэж байна. Тиймээс энэ хуулийг цаг үеийн шаардлагад нийцүүлж шинэчлэх зайлшгүй шаардлага үүсээд буй нь ойлгомжтой.

Мэдээлэл олж авах эрх, эрх чөлөөний тухай хуулийг өмнөх УИХ-аар батлан гаргасан. Энэ хуультай уялдуулж, цаг хугацаатай нь нийцүүлж Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийг шинэчилж, нийгэмд шаардлагатай эрх зүйн зохицуулалтуудыг оруулж чадсан хууль болоосой гэж боддог. Мэдээлэл олж авах эрх, эрх чөлөөний тухай хууль батлагдсан ч гэсэн сэтгүүлчид өнөөдөр өөрсдийн хардаж сэрдэж байгаа асуудлаар, мөн төрийн зарим байгууллагаас мэдээлэл олж авахад бас л төдийлөн энэ хууль үйлчилж чадахгүй байна уу даа гэж боддог. Хуулийн дагуу бүх мэдээллийг гаргаж нээж өгч чадахгүй байгаа нь ажиглагддаг.

Хэвлэл, мэдээллийн олон байгууллага байна. Үүний цаана тодорхой эзэд байдаг. Эзний байр суурь, сэтгүүлчийн бичих эрхийн уялдаа ямар байх ёстой вэ. Эзэд редакцийн нийтлэлийн бодлогод сэтгүүлчийн бичих эрхэд оролцох ёстой юу, үгүй юү. Үүнийг зохицуулж өгөх ёстой. Сэтгүүлчид биеэ даагаад байр сууриа илэрхийлж бичиж буй үед хэвлэл, мэдээллийн байгууллага нь түүний бичих эрхийн баталгааг хангадаг байх шаардлагатай. Жишээ нь, нийгэмд бугшиж байгаа асуудлаар эрэн сурвалжилж асуудал дэвшүүлэхэд эргээд редакц, хэвлэл, мэдээллийн байгууллага нь найдвартай баталгаа болж чаддаг байх тийм зохицуулалт хуульд ороосой гэж бодож байна. Бас “Эрүүгийн хууль”-ийн холбогдох заалтад өөрчлөлт оруулах байх. Бусдын нэр төрд халдаж гүтгэх доромжлох гэдэг нь заавал Эрүүгийн хуулиар зохицуулагдах гэмт хэрэг мөн үү гэдэг бас эргэлзээтэй. Эдгээр олон зохицуулалтыг хуульд оруулаасай. Сэтгүүлчийн хүнд хөдөлмөрийг ойлгосон, зохицуулалтыг нь хийсэн тийм хууль болж чадаасай гэж найдаж байна.

“Зууны мэдээ” сонины Улс төрийн албаны сэтгүүлч М.Ганцэцэг:

-Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль гэхээр манай сэтгүүлчид илүү эрх чөлөөг нэхээд байдаг. Гэтэл үүний цаана хараат бус байдал, хариуцлага гэсэн хоёр тулгуурыг энэ хуулиас илүү хүлээх хэрэгтэй байх гэж боддог. Хууль санаачлагч гишүүдийн хувьд энэ хуулиас нэг их зүйл хүлээх хэрэггүй гэдгийг хэлж байгаа. Зөвхөн эрх чөлөөг нь үүгээр тунхаглаад бусад зүйлийг өөр хуулиар зохицуулах байх гэж бодож байна.

Эх орон телевизийн сэтгүүлч Э.Нэргүй:

-Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийг анх 1998 онд баталж гаргаж байсан бол түүнээс хойш өнөөдрийг хүрэхэд олон зохицуулалтыг шинээр хийх шаардлага үүссэн байна. Энэ удаагийн УИХ энэ хуулийг гартаа авч хэлэлцэж байгаад баяртай байна. Сэтгүүлч хүний хувьд хэлэхэд Хэвлэлийн эрх чөлөөний хуульд сэтгүүлчийн үгээ хэлэх эрхийг нэлээд сайн гаргаж өгсөн хууль байгаасай гэж боддог.

Өнөөдрийн нийгэмд сэтгүүлч хүн яг өөрийнхөөрөө дуугарах эрх чөлөө хомс байгаа нь ажиглагддаг. Эзний юм уу, редакцын хараат байдлаар ажилладаг хэвлэлүүд байсаар байна. Тухайлбал, аль нэг улстөрчийн алдааг шүүмжлэх хэрэгтэй байлаа гэхэд эзнийхээ юм уу, редакцынхаа захиалгаар тэр улстөрчид халдаж чадахгүй байх тохиолдол гардаг нь анзаарагддаг. Тиймээс Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуульд нэгдүгээрт, хэвлэлийн эрх чөлөөг тунхаглах, нөгөө талаас сэтгүүлчийн ажлаа шударгаар, хараат бусаар хийх нөхцөлийг хангаж өгсөн зохицуулалтыг хийж өгөөсэй гэж бодож байна.

Shuud.mn сайтын сэтгүүлч Н.Түвшинжаргал:

-Сэтгүүлчдэд хамгийн түрүүнд тулгамддаг асуудал бол цагдаа, шүүхийн байгууллагас ирдэг дарамт байдаг. Эрүүгийн хуульд байдаг бусдыг гүтгэн доромжилсон бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ гэсэн заалт үүнд их нөлөөлдөг. Хэдийгээр нөгөө тал буруутай байсан ч эрх сүрээр далайлгаж Эрүүгийн хуулийн

заалтыг барьж сэтгүүлчийг яллах сэжим болдог. Энэ нь сэтгүүлч хэвийн үйл ажиллагаа явуулах, ээдрээтэй асуудлыг эрэн сурвалжлах нөхцөл боломжийг тасалдуулдаг. Сэтгүүлчийн хууль ёсны эрхийг зөрчдөг. Тэгэхээр Эрүүгийн хуулийн холбогдох зүйл заалтыг өөрчилж, үнэхээр алдаа гаргасан байлаа гэхэд захиргааны юм уу, иргэний журмаар шийдвэрлэдэг болчихвол сэтгүүлчдэд ирэх дарамт багасна. Сэтгүүлчийн эх сурвалжаа нууцлах эрхийг бас хадгалж өгөх хэрэгтэй байдаг. Хуульд үүнийг тусгасан ч практик дээр хэрэгждэггүй. Үүнийг баталгаажуулж өгөх хэрэгтэй гэж үзэж байгаа.

Монголын сэтгүүлчдийн эвлэлийн ерөнхийлөгч Б.Галаарид:

-Энэ хуулийн төслийг бараг гурван жил хэлэлцэж байна. Өнгөрсөн хугацаанд хэвлэл мэдээллийн ажилтнууд, энэ салбарт ажилладаг хүмүүс, эрдэмтэн судлаачид, улстөрчид гээд хэвлэл мэдээллийн салбартай холбоотой, ойр дөт байдаг нийгмийн бүлгүүд маш олон удаа санал бодлоо илэрхийлж, хэлэлцсэний үндсэн дээр УИХ-ын чуулганаар оруулж байна. Мөн энэ хууль хоёр ч парламент дамжлаа. Өмнөх парламент сэтгүүлчдэд хэтэрхий эрх чөлөө өгсөн, дэндүү либераль хууль гэж үзээд эсрэг хуулийг нь хүртэл сөргүүлэн тавьж саармагжуулах гэж оролдож байсан. Энэ хуулийг санаачилсан Монгол Улсын Ерөнхийлөгч өөрөө сэтгүүлч хүн. Нөгөөтэйгүүр ардчиллын үнэ цэнийг дээд зэргээр ухаарч ойлгож эрхэмлэдэг улстөрч гэдэг утгаараа энэ хуулийг санаачилсан байх.

Гэтэл сүүлийн үед энэ хуультай холбоотойгоор “Хэвлэлийн эрх чөлөөг боомилох гэж байна” гэсэн яриа гараад байгааг огт ойлгохгүй байна. Ажлын хэсэг дээр хуулийн төсөл хэлэлцэх явцад манай салбартай холбоотой асуудлыг янз бүрийн л өнцгөөс ярьсан. Гэхдээ Ерөнхийлөгчөөс өргөн барьсан тэр либераль хуулийн төслийн амин сүнснийг нь хэвээр хадгалахыг чухалчилсан шүү дээ. Тиймээс хэвлэлийн эрх чөлөөг боомилох гэж байна гэдэг яриаг үнэхээр ойлгохгүй байна.

-Миний бодлоор бол хараат бус байдлын баталгаа байх ёстой. Бидний зорьж, хүсч, тэмүүлээд байгаа хөгжингүй ардчилал гэдэг зүйл маань өөрөө энэ л зарчмыг шаардаж байгаа шүү дээ. Эзэн, сэтгүүлч, редакци гурвын хоорондын хариуцлага, эрх үүргийн тогтолцоо байж гэмээнэ гурвуулаа хэн хэндээ саад болохгүй, эцэстээ бүгдээрээ сэтгэл хангалуун үлдэх зөв тогтолцоо бүрэлдэнэ. Үүнийг одоогийн нөхцөлд хуулиар л зохицуулна” хэмээн хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн ач холбогдлыг мэргэжлийн хүмүүс дүгнэж байна.